



**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2020 он

Судалгааны захиалагч: “Иргэдийн оролцоо” төсөл

Судалгааны гүйцэтгэгч: Өмгөөллийн “Монгол Өмгөөлөгч” ХХН

Судалгааны баг: **Тайлан боловсруулсан:**

Багийн удирдагч З.Сүхбаатар (Бизнесийн удирдлагын доктор /Ph.D/), Нөхөрлөлийн захирал

Багийн ахлагч Т.Энхбулгантамир (Хууль зүйн магистр), Нөхөрлөлийн гишүүн, өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Эрдэнэцэцэг (Хууль зүйн магистр), ахлах өмгөөлөгч

Багийн гишүүн А.Гулим, өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Шүрэнцэцэг, өмгөөлөгч

Багийн гишүүн М.Энхзул, хуульч

АГУУЛГА

УДИРТГАЛ	6
НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	6
1.1 АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛЖ ШИЙДВЭРЛЭХ ГЭЖ БАЙГАА ТУХАЙН АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ	8
1.2 ТУХАЙН АСУУДЛААР ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БАЙГАА НИЙГМИЙН БҮЛЭГ, ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БУСАД ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ.....	43
1.3 ТУХАЙН АСУУДАЛ ҮҮССЭН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ	46
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ НЬ.....	47
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ОЛЖ ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ	49
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДЛАХ НЬ 55	
4.1 ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ ...	56
4.2 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, БУСАД ХУУЛЬТАЙ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ.....	57
4.3 ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААРХ НИЙГМИЙН ШААРДЛАГА	59
4.4. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	61
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	64
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	67
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ.....	85
ХАВСРАЛТ 1 (Хувь хүний нууцын талаар зохицуулалт агуулсан хуулийн түүвэр).....	
ХАВСРАЛТ 2 (Мэдээллийн аюулгүй байдлын талаар зохицуулалт агуулсан хуулийн түүвэр).....	
ХАВСРАЛТ 3 (Хүний эрх, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө).....	

УДИРТГАЛ

Энэхүү “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгаа” сэдэвт судалгааны ажлыг захиалгад үндэслэн Өмгөөллийн “Монгол Өмгөөлөгч” ХХН-ийн хуульч, судлаачид хийж гүйцэтгэлээ.

Дэлхий дахинаа мэдээллийн технологи хурдацтай хөгжихийн хэрээр иргэн, төр, бизнесийн байгууллагуудын хоорондын харилцааг илүү оновчтой, түргэн шуурхай болгох зорилгоор цахим засгийг хөгжүүлэх, төрөөс иргэд, хуулийн этгээдэд чиглэсэн цахим үйлчилгээг дэмжих, төрийн мэдээллийг ил тод нээлттэй болгох шаардлага үүсэж байгаатай холбогдуулан төрөөс мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ялангуяа хувь хүн, иргэний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүсээд байна. Хэдийгээр энэ талаар мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх асуудал бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж, хэрэгжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрч байгаа боловч Хувь хүний мэдээллийг тодорхой зорилгоор ашиглах, боловсруулах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах харилцааг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомж байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д *Өгөгдөл хамгаалах тухай хуулийг Засгийн газар санаачлан боловсруулах* гэж,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.2-т *“Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх”* гэж, 4.1.6-д *“Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.”* гэж,

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Мэдээллийн аюулгүй байдал” Зорилт 7.5 дахь хэсэгт *“Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.”* гэж,

Мөн тус баримт бичгийн “Засаглалын бодлого” хэмээх Тавдугаар бүлгийн зорилгыг цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих гэж тодорхойлсон бөгөөд тус баримт бичгийн Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) хэсгийн зорилтыг тодорхойлохдоо *“хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхээр, уг зорилтын хүрээнд 2021-2030 оныг мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх”* гэж,

Монгол Улсын Их хурлын 2018 оны 54 дүгээр тогтоол (Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай)-ын 2

дахь заалтад *“төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах”* гэж тус тус заасан.

Иймд дээр өгүүлсэн цогц зорилтын хүрээнд Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг болон Засгийн газрын 2016 оны 59 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын /цаашид “Аргачлал” гэх/ 2.1-д заасан дараах үе шатны дагуу хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах зэрэг болно.

НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хувь хүний мэдээлэл хамгаалахад тулгарч буй асуудлыг тодорхойлж, тухайн асуудалд дүн шинжилгээ хийхийн өмнө “хувь хүн”, “мэдээлэл” гэсэн нэр томъёог авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хүн гэдэг нэр томъёо нь хууль зүйн шинжлэх ухаанд болон эрх зүйн сэтгэлгээнд ямарваа нэг төрөөс үл хамаарах байдлаар тодорхой эрх, эрх чөлөөг байгалиас /төрөлхийн эрх/ уламжлан авсан этгээдийг заасан утгаар хөгжиж ирсэн байна. Хүн, хүний эрхийн асуудал нь олон улсаар хамгаалагддаг, олон улсын нийтийн эрх зүйн болон үндсэн хуулийн ойлголт болдог.¹

Нөгөө талаас хүн гэдэг нь байгалийн төдийгүй нийгмийн “амьтан”. Хүн нийгмийн харилцаанд оролцогч “этгээд” болохыг хувьд түүний сэтгэхүй, сэтгэлгээ, зан төлөв, хэл яриа, ажиллах чадвар зэрэг нь зөвхөн нийгэмд төлөвшин хөгждөг.²

Хувь хүн гэсэн нэр томъёо нь ямар нэгэн шалгуур, үнэлэлтгүйгээр тухайн хүний байгаа байдлыг илэрхийлдэг байна.³

Монголын “Эрх зүйн эх толь бичиг”-т “Хувь хүн (individual) гэдэг нь биологийн зүйлийн шинжийг агуулсан, онтогенез, филогенез хөгжлийн бүрэлдэхүүн”⁴ гэж тайлбарлажээ.

Эрх, эрх чөлөөтэй холбоотой олон нэр томъёо Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэд орсон байдаг. Үүнд: хүний эрх, иргэний эрх, үндсэн хуульд заасан эрх, хувь хүний эрх, үндсэн эрх гэх мэт. Нийтлэг үнэлэмж мөн бусдаас ялгарах шинж чанараар нь хувь хүнийг эрх зүйн этгээд хэмээн үзнэ.⁵

Харин “мэдээлэл” гэдгийг хэл зүйн утгаар нь ямар нэгэн үйл явцын тухай ам болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх явц, мэдээ дамжуулах, түгээхийг⁶ хэлнэ гэж тодорхойлсон бол Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/477 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах /ерөнхий/ журам”-д “мэдээлэл” гэж эзэмшиж, хадгалж байгаа төхөөрөмжөөс үл хамааран боломжит бүхий л хэлбэрээр оршин байгаа уншиж ойлгож болох, бүх төрлийн баримт бичиг, мэдээ, мэдээлэл, биет зүйлсийг ойлгох тухай тусгасан байна.⁷

Түүнчлэн бусад улсын хувь хүний мэдээлэл хамгааллын талаарх баримт бичигт “хувийн мэдээлэл” гэдгийг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл:

Европын холбооны өгөгдөл хамгаалах ерөнхий хууль (2016)-ийн 4.1-т тодорхойлсноор “хувийн мэдээлэл” гэдэг нь тухайн хувь хүнийг таних боломжтой байдлаар тодорхойлсон эсхүл тодорхойлохуйц аливаа мэдээлэл болно. Таних боломжтой хувь хүн гэдгийг шууд буюу шууд бусаар тодорхойлох дугаар, байршлын мэдээлэл, цахим тодорхойлогч эсхүл түүний биеийн, физиологийн,

¹ Монгол Улсын Иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001-2002), УБ 2018., 803 дахь тал.

² Ж.Амарсанаа, Хууль зүйн нэр томъёоны булан, Хууль дээдлэх ёс сэтгүүл (№3), 2019 он, 135-136 дахь тал

³ Мөн тэнд

⁴ Монголын эрх зүйн эх толь бичиг(дөрөв дэх хэвлэлт), УБ 2015., 521-522 дахь тал.

⁵ Ц.Сарантуяа, Үндсэн хууль төр ба үндсэн эрх, эрх чөлөө эрдэм шинжилгээний өгүүлэл, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа, шинжилгээний тойм. УБ 2019., 137-138 дахь тал.

⁶ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, 5 боть. Шинжлэх ухааны академи, УБ., 2007 он, М-С, 1289 дэх тал

⁷ Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/477 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах /ерөнхий/ журмын 2.1 дэх хэсэг.

сэтгэл санааны, эдийн засгийн, соёлын эсхүл нийгмийн ялгарах шинж тэмдгээр нь тодорхойлохыг хэлнэ гэжээ.⁸

Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн хуулийн загвар (2018)-ын 2 дугаар зүйлд зааснаар тодорхой хүний талаарх “хувийн мэдээлэл” гэдэг нь тухайн хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох эсхүл тодорхойлж чадахуйц аливаа мэдээлэл болно. Хувийн мэдээлэл гэдэгт тухайн хүний овог, нэр, гадаад төрх байдал, түүх намтрын болон таних өгөгдөл, хувийн шинж чанар, гэр бүл, нийгмийн байдал, боловсрол, мэргэжил, ажлын болон санхүүгийн байдал, эрүүл мэндийн байдал болон бусад мэдээлэл багтахар тодорхойлсон байна.⁹

Дээрх тайлбар, тодорхойлолтоос үзвэл хувь хүний мэдээлэл гэдгийг тухайн хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлохуйц бүхий л мэдээлэл гэж ойлгохоор байна. Үүнд: тухайн хүний овог, нэр, бусдаас таних, ялгах бүхий л мэдээлэл, түүх намтар, хувийн шинж чанар, гэр бүл, нийгмийн байдал, боловсрол, мэргэжил, ажлын болон санхүүгийн байдал, эрүүл мэндийн байдал, эзэмшиж байгаа эрх, өмч хөрөнгө, харилцаа холбооны дугаар, хаяг болон бусад мэдээлэл зэрэг өргөн хүрээнд авч үзэж байна. Өөрөөр хэлбэл, хувь хүн бүр өөрийг нь тодорхойлох мэдээллийг тээгч байдаг бөгөөд тэрхүү мэдээллийнхээ эзэмшигч нь болох юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, 17 дахь хэсэгт “...Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын актын 17.1 дэх хэсэгт “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.” гэж, 17.2 дахь хэсэгт “Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.” гэж,

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан.

Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зохицуулалтын агуулгаас үзвэл хувь хүний мэдээллийн тодорхой хэсэг болох хувийн ба гэр бүл, захидал харилцаа, орон байрны мэдээллийг нууцад хамааруулан хууль зүйн хамгаалтад авсан байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн Хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаалах зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Их Хурал 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталсан. Тус хуулиар хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байхаар хуульчилсан. Үүнд:

1/захидал харилцааны нууц;

2/эрүүл мэндийн нууц;

⁸ Европын холбооны өгөгдөл хамгаалах ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг <https://gdpr-info.eu/art-4-gdpr/>

⁹ Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн хуулийн загвар (2018), 2 дугаар зүйл. <https://cis-legislation.com/document.fwx?rgn=116757>

- 3/хөрөнгийн нууц;
- 4/гэр бүлийн нууц;
- 5/хуулиар тогтоосон бусад нууц.

Дээрх хуулийн зохицуулалтаас Монгол улсад хувь хүний мэдээллийн зарим хэсгийг хувь хүний нууц гэж хуулиар тогтоосон байх бөгөөд төр болон хувийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цуглуулж байгаа харилцааг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулах боломжгүй байна.

Өөрөөр хэлбэл, хувь хүний нууц нь хувь хүний мэдээллийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд хувь хүний нууц нь зөвхөн тодорхой хүрээний хувь хүний нууцлах шаардлагатай мэдээлэлд хамаарч байна.

Хувь хүний мэдээлэл хамгаалалт ба хувь хүний нууцын хооронд давхцал гардаг бөгөөд олон улсын шүүхээс мэдээлэл хамгаалах дэглэмийн тодорхой элементүүд хувь хүний нууцтай байх эрхийн баталгаа болдог гэж үзсэн байна.¹⁰

Энэ нь хувь хүний нууц болон хувь хүний мэдээлэл хамгаалах харилцааны зааг, ялгааг гаргаж, тус тусад нь зохицуулах шаардлагатай болохыг харуулж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи хөгжихийн хирээр мэдээлэл хүлээн авах, цуглуулах төрөл, хэлбэр улам өсөн нэмэгдэж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагааг бий болгосноор хувь хүний мэдээлэл нь эдийн засгийн эргэлтэд орж, баялаг бүтээх нэг боломж болж байгаа сайн талтай хэдий ч нөгөө талаар хувь хүний мэдээлэл алдагдах, буруугаар ашиглагдах, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглаж, боловсруулах замаар хувь хүний эрх, эрх чөлөөнд халдах эрсдэлийг дагуулж байна.

1.1. АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛЖ ШИЙДВЭРЛЭХ ГЭЖ БАЙГАА ТУХАЙН АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Асуудалд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд хувь хүний мэдээлэл хамгаалах асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох зорилгоор хувь хүний мэдээлэл хамгаалах талаар өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг судлах, Монгол Улсад хувь хүний мэдээлэлтэй холбогдон гарч буй гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдлыг судлан тогтоох зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас нөхцөл байдлын талаарх лавлагаа, статистик тоон мэдээлэл цуглуулах, хувь хүний мэдээллийг цуглуулж, хадгалдаг байгууллагын төлөөлөл болон иргэдээс хувь хүний мэдээлэл хамгааллын талаар цахимаар судалгаа авах, энэ асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, мэдээллийг судлах хэлбэрээр тоон болон чанарын судалгаа хийсэн.

Түүнчлэн Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийг шинээр боловсруулж баталснаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

¹⁰ Монгол Улс Хэвлэл мэдээллийн эрх зүй. Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх (Сургалтын гарын авлага), Глоб интернэшнл төв болон DW akademie, 2017., 27-28 дахь тал.

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Нэг. Хууль тогтоомж

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт *“...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”*, мөн 17 дахь хэсэгт *“төр, түүний байгууллагаас - хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”* гэж заасан.

Монгол Улсын Их Хурал 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, уг хуулиар хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж, хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болохоор тусгасан.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т зааснаар мэдээллийн аюулгүй байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар хуульчилсан.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Архивын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Банкны тухай хууль, Гаалийн тухай хууль хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Монгол улсын Шүүхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нотариатын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Соёлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай зэрэг хуулиудад хувь хүний нууцыг хамгаалах, зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглосон нийтлэг зохицуулалт тусгагдсан байна. (Дээрх хуулийн заалтуудын түүврийг Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн харна уу.)

Түүнчлэн Эрүүгийн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль зэрэг хуулиудад мэдээллийн аюулгүй байдлын талаар зохицуулалт тусгагдсан байна. (Дээрх хуулийн заалтуудын түүврийг Хавсралт 2-оос дэлгэрүүлэн харна уу.)

Хувь хүний нууцын тухай хууль болон дээр дурдсан хуулиудын зохицуулалт нь хувь хүний нууцыг хамгаалах, зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглосон хэт ерөнхий агуулгатай байх бөгөөд хувь хүний мэдээллийг цуглуулах, бүртгэх, хадгалах, хамгаалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад хувь хүн болон хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээд хоорондын эрх зүйн харилцааг цогцоор нь зохицуулаагүй байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх талаар дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсийг *“Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.”* гэж заасан.

Мөн үзэл баримтлалын 3.6.2.3-т *“Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно,*

3.6.3.1-т *“Мэдээлэл, түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задрахаас хамгаалагдсанаар нууцлал хангагдана”,*

3.6.3.7-д *“Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглоно.”* гэж тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.2-т *“Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ”,*

4.1.6-д *“Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.”* гэж заасан.

Монгол Улсын Их хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.3.3-т *“шуудан холбоо, үүрэн телефон, интернэтийн үйлчилгээний байгууллагуудын иргэний хувийн болон захидал харилцааны нууцыг хамгаалах талаар стандарт тогтоож мөрдүүлэх, төрийн хяналтын систем тогтоох, эрх бүхий байгууллагын шийдвэрээр иргэний хувийн нууцтай танилцсан, чагнасан тохиолдол бүрийг бүртгэх журам, тогтолцоог бий болгоно”, 2.1.3.4-т “Иргэний хувийн болон захидал харилцаа, гэр бүл, эрүүл мэнд, эд хөрөнгийн нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ хохирогчид нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх...” мөн 2.1.3.5-д “Хувь хүний нууцын тухай хуулийг тодорхой болгох, хувийн болон гэр бүлийн, захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, тэдгээрийг агуулсан зүйлсийн жагсаалтыг гаргах, хүний хувийн нууцтай холбоотой ажил үйлчилгээ эрхэлдэг бүх хэвшлийн байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулах, амлалт авахуулах зэргээр хариуцлагыг дээшлүүлнэ”* гэж заасан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлийн 5.4.4-т *“Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ”* гэжээ.

Түүнчлэн Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын 11-ний 204 дүгээр тогтоолоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан. Уг төлөвлөгөөний наймдугаар хэсэгт: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр зөвлөмжид тусгаснаас гадна хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон гол үүрэг хүлээх субъектүүдийг тодорхой зааж өгсөн байна.

Ийнхүү төрийн бодлогын баримт бичгүүдэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх талаар тусгагдаж, тодорхой үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах харилцааг тусгайлан зохицуулсан хууль байхгүй байна.

Хоёр. Олон улсын эрх зүйн баримт бичиг

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйлд *“Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”* гэж,

Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пактын 17.1 дэх хэсэгт *“Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.”* гэж, 17.2 дахь хэсэгт *“Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.”* гэж,

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 45/95 тоот тогтоолоор¹¹ Компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийг зохицуулах удирдамжийг баталж, түүнд үндэсний хууль тогтоомжоор өгөгдөл хамгаалахтай холбоотой үндсэн зарчмуудыг дараах байдлаар нэгтгэн тогтоосон¹²:

- Хууль ёсны болон шударга ёсны зарчим: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь шударга, хууль ёсны байх ёстой бөгөөд НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчимд харшлах ёсгүй.

- Үнэн зөв байх зарчим: өгөгдөл хянагчид өгөгдлийг үнэн зөв, хамааралтай байгаа эсэхийг шалгаж, хянах үүрэгтэй бөгөөд алдаа гаргахаас зайлсхийх ёстой.

- Тодорхой зорилгоор ашиглах зарчим: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь хууль ёсны байх ёстой бөгөөд хувийн өгөгдлийг зөвхөн тусгайлсан зорилгын дагуу цуглуулж, боловсруулах, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр өгөгдлийг бусад этгээдэд ашиглуулахгүй байх, өгөгдөл нь зөвхөн тухайн зорилгод шаардлагатай хугацаагаар хадгалагдах ёстой.

¹¹ Монгол Улс Хэвлэл мэдээллийн эрх зүй. Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх (Сургалтын гарын авлага), Глоб интернэшнл төв болон DW akademie, 2017 он

¹² <https://digitallibrary.un.org/record/85149?ln=en#record-files-collapse-header>

- Сонирхогч этгээд нэвтрэх боломжтой байх зарчим: өгөгдлийн эзэн тухайн өгөгдлийг хэрхэн ойлгомжтой хэлбэрээр цуглуулах, боловсруулах, нэвтрэхийг мэдэх эрхтэй байх ёстой.

- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эдгээр зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд ялгаварлан гадуурхах аливаа онцгой тохиолдол гэж байх ёсгүй.

- Аюулгүй байдлын зарчим: зөвшөөрөгдөөгүй этгээд хандах, урвуулан ашиглах, гэнэтийн хүчин зүйлийн улмаас устах зэрэг байгалийн болон хүнээс хамаарах эрсдэлээс өгөгдлийг хамгаалах зохистой арга хэмжээ авах ёстой.

Монгол Улсын Их хурлаас 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр баталсан Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 7 дугаар зүйлд *“Энэхүү конвенц нь Талуудын хувийн мэдээлэл, оршин байгаа газар, бусад мэдээллийг ил болгохыг шаардсан хууль тогтоомжийг хэрэглэх болон үүнтэй холбогдуулан буруу, таашаа, эсхүл бүрэн бус мэдээлэл өгсөн Талыг эрх зүйн үр дагавраас чөлөөлөх асуудлыг хөндөхгүй.”*, мөн 14.1 дэх хэсэгт *“Хувь хүн автоматжуулсан мэдээллийн системээр дамжуулан нөгөө Талд хүргүүлсэн цахим харилцаанд алдаатай мэдээлэл оруулсан бөгөөд тэрхүү автоматжуулсан мэдээллийн систем тухайн алдааг засах боломжийг түүнд олгоогүй бол тэр хувь хүн, эсхүл түүгээр төлөөлүүлсэн Тал алдаа гарсан цахим мэдээллийн хэсгийг хүчингүй болгох эрхтэй”* гэж тус тус тусгасан.

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛЛЫН ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГАА

Монгол Улсад хувь хүний мэдээлэл хамгааллын талаар тулгамдаж буй асуудлуудын мөн чанар, цар хүрээг тодорхойлох зорилгоор “Монгол Өмгөөлөгч” ХХН-ийн зүгээс 21 асуултын хүрээнд санал асуулгын аргаар иргэдээс судалгаа авсан болно. Судалгааг иргэдээс цахим орчинд онлайн хэлбэрээр цуглуулсан бөгөөд судалгаанд нийт 507 иргэд хамрагдсан.

Иргэдээс авсан судалгааны анкетын загвар:

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ САНАЛ АСУУЛГА

Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Энэхүү санал асуулгын зорилго нь Монгол Улсад хувь хүний мэдээллийг хамгаалах, цуглуулах, боловсруулах, ашиглах явцад тулгарч буй асуудлуудыг тодруулахад оршино.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

ХЭСЭГ I. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас

- а. 18 хүртэл
- б. 18-35 хүртэл
- в. 36-45 хүртэл
- г. 46-с дээш

ХЭСЭГ II. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ, ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТ

- 1. Та ихэвчлэн интернэтэд хаанаас холбогддог вэ?**
 - а. гэрээсээ
 - б. ажил дээрээсээ
 - в. бусад
- 2. Та интернэт ашиглан ямар үйлчилгээ ихэвчлэн авдаг вэ?**
 - а. нийгмийн сүлжээ (facebook, инстаграм г.м)
 - б. банкны үйлчилгээ
 - в. харилцаа холбооны үйлчилгээ
 - г. бусад үйлчилгээ
- 3. Төрийн болон хувийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэхдээ танаас нэмэлт хувийн мэдээлэл шаарддаг уу?**
 - а. шаарддаг
 - б. шаарддаггүй
 - в. зарим тохиолдолд шаарддаг
- 4. Төрийн болон хувийн байгууллагууд хувь хүний мэдээллийг ямар зорилгоор цуглуулдаг гэж та боддог вэ?**
 - а. Зөвхөн дотоод үйл ажиллагаандаа ашигладаг гэж итгэдэг
 - б. мэдэхгүй
- 5. Таны хувийн мэдээлэл цахим орчинд алдагдахад үүсч болох хамгийн ноцтой эрсдэл юу байдаг вэ?**
 - а. мэдэгдэлгүйгээр хувийн мэдээллийг ашиглах, боловсруулах бусдад дамжуулах
 - б. миний хувийн мэдээллийг бусдыг хууран мэхлэх, залилах зорилгоор ашиглагдах
 - в. бусад буруугаар ойлгогдох, гадуурхагдах, нэр хүндээ алдах
 - г. амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учрах
- 6. Цахим үйлчилгээ, нийгмийн сүлжээ ашиглахад тэдгээрийн нууцлалын мэдэгдлийг та уншдаг уу?**

- а. огт уншдаггүй
б. хэсэгчлэн уншдаг
7. **Цахим орчин дахь хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь хэнээс хамаарна гэж та үзэж байна вэ?**
а. хувь хүнээс өөрөөс нь
б. төрөөс
в. Мэдэхгүй
8. **Та өөрийн хувийн мэдээллээ цахим орчинд олон нийтэд нээлттэй байдлаар оруулах тохиолдолд хувийн мэдээлэлдээ бүрэн хяналт тавьж чаддаг уу?**
а. бүрэн хяналт тавьж чаддаг
б. хяналт тавьж чаддаггүй
в. мэдэхгүй
9. **Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах шаардлагатай юу?**
а. Тийм
б. Заавал бичгээр авах шаардлагатай
в. Зарим тохиолдолд шаардлагатай
10. **Аливаа нийгмийн сүлжээний профайл дээрх үндсэн тохиргооноос хувийн нууцлалын тохиргоог өөрчилж байсан уу?**
а. хувийн нууцлалын тохиргоог өөрчилж байсан
б. хувийн нууцлалын тохиргоог өөрчлөх боломжгүй байдаг
в. тохиргоог хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй
11. **Таны хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулалт хийхээс өмнө өөрөөс тань зөвшөөрөл авах шаардлагатай гэж үздэг үү?**
а. заавал зөвшөөрөл авах шаардлагатай
б. эмзэг мэдээлэлтэй (эрүүл мэнд, бэлгийн чиг хандлага гэх мэт) холбоотой тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагатай
в. шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авах нь зөв
12. **Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад өгсөн таны хувийн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт хэр итгэлтэй байдаг вэ? /олон хариулт сонгоно/**
а. Итгэдэг
б. Итгэдэггүй
в. Зөвхөн төрийн байгууллагад итгэдэг
г. Зөвхөн банк санхүүгийн байгууллагад итгэдэг
д. Зөвхөн эрүүл мэндийн байгууллагад итгэдэг
е. Зөвхөн гар утасны операторуудад итгэдэг
13. **Таны хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор танд мэдэгдэлгүйгээр дахин ашиглахыг та зөвшөөрөх үү?**
а. огт зөвшөөрөхгүй
б. зөвшөөрнө
в. мэдэхгүй
14. **Та төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хадгалагдаж байгаа хувийн мэдээллээ устгуулж байсан уу?**
а. Тийм
б. Үгүй
15. **Нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулах нь зөв үү?**
а. Зөв
б. Буруу
в. Мэдэхгүй
16. **Нийтийн эзэмшлийн гудамж талбайд ямар зорилгоор дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулдаг гэж та боддог вэ?**
а. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.
б. Мэдэхгүй.
в. Сонирхож байгаагүй юм байна.
17. **Таны хувийн мэдээлэл өмнө нь ямар нэгэн байдлаар алдагдах эсвэл ил болох тохиолдол тулгарч байсан уу?**
а. тийм
б. үгүй
в. мэдэхгүй
18. **Хувийн мэдээллээ алдсан тохиолдолд та хаана хандах вэ?**
а. цагдаагийн байгууллага

- б. Хүний эрхийн үндэсний комисс
 - в. Мэдэхгүй
- 19. Хувийн мэдээллийг тусгайлсан хуулиар хамгаалах шаардлагатай юу?**
- а. Тийм
 - б. Үгүй
 - в. Мэдэхгүй
- 20. Хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай юу?**
- а. Тийм
 - б. Үгүй
 - в. Мэдэхгүй

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА


Нэг. Иргэдээс авсан судалгааны дүн

ИРГЭДИЙН СУДАЛГАА

СУДАЛГААНД ХАМРАГДАГСДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд нийт 18-60 насны 507 иргэн хамрагдсанаас 18-35 насныхан 62%, 36-45 насныхан 31%, 46-аас дээш насныхан 6%-ийг эзэлж байна.

Зураг 1: Судалгаанд хамрагдсан иргэд насны бүлгээр



ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ

Интернэт ашиглаж буй байршил

Хаанаас ихэвчлэн интернэтэд ордог болохыг тодруулахад 18-35 насны 10 иргэн тутмын 7 нь, 36-45 насны 10 иргэн тутмын 6 нь гэрээсээ интернэтэд орж байна.

Хүснэгт 1: Интернэт ашиглаж буй байршил (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гэрээсээ	6	100%	218	69%	91	59%	22	71%	337	66%
Ажил дээрээсээ	1	17%	85	27%	63	41%	6	19%	155	31%
Бусад	1	17%	18	6%	2	1%	3	10%	24	5%
Нийт	6		315		155		31		507	

Интернэт ашигладаг зорилго

Интернэтээс авдаг үйлчилгээг тодруулахад 370 судалгаанд оролцогч буюу 73% нь нийгмийн сүлжээ буюу facebook, инстаграм орох гэж интернэт ашигладаг байна.

Зураг 2: Судалгаанд оролцогчдын интернэт ордог зорилго



Интернэт орж буй зорилгыг насны бүлгээр харвал нийгмийн сүлжээг залуу насныхан, банкны үйлчилгээг нас ахих тусам ашиглах хандлага өндөр байна.

Хүснэгт 2: Интернэт ордог зорилго (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийгмийн сүлжээ (facebook, инстаграмм г.м)	5	83%	241	77%	104	67%	20	65%	370	73%
Банкны үйлчилгээ	0	0%	33	10%	28	18%	10	32%	71	14%
Харилцаа холбооны үйлчилгээ	0	0%	44	14%	11	7%	2	6%	57	11%
Бусад үйлчилгээ	1	17%	23	7%	24	15%	4	13%	52	10%
Нийт	6		315		155		31		507	

ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН БАЙГУУЛЛАГУУД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХДЭЭ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ ШААРДДАГ ЭСЭХ

Судалгаанд хамрагдсан иргэдээс төрийн болон хувийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэхдээ нэмэлт мэдээлэл шаарддаг эсэхийг тодруулахад 59% нь нэмэлтээр хувийн мэдээлэл өгөхийг шаарддаг гэсэн бол үүнээс 9% нь өөрийн хувийн мэдээллийг өгөхөөс өөр сонголт байдаггүй гэсэн бол 5% нь бүтээгдэхүүн үйлчилгээ авахын тулд өөрийн хувийн мэдээллээ өгөх нь асуудал биш гэж үзэж байна. Тухайн үзүүлэлтийг насны бүлгээр харвал төдийлөн ялгаатай зүйл байхгүй байна.

Хүснэгт 3: Төрийн болон хувийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэхдээ нэмэлт мэдээлэл шаарддаг эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нэмэлт хувийн мэдээлэл өгөхийг шаарддаг	1	17%	138	44%	73	47%	12	39%	224	44%
Өөрийн хувийн мэдээллийг өгөхөөс өөр сонголт	0	0%	36	11%	12	8%	0	0%	48	9%

байдаггүй										
Бүтээгдэхүүн үйлчилгээ авахын тулд өөрийн хувийн мэдээллээ өгөх нь том асуудал биш	0	0%	18	6%	6	4%	0	0%	24	5%
Хувийн мэдээллийг цахим хэлбэрээр өгөх нь зайлшгүй шаардлагатай	0	0%	2	1%	1	1%	0	0%	3	1%
Зарим тохиолдолд шаарддаг	5	83%	99	31%	51	33%	14	45%	169	33%
Шаарддаггүй	0	0%	22	7%	12	8%	5	16%	39	8%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

ЦАХИМ ОРЧНЫ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

Цахим орчинд хувийн мэдээлэл алдагдахад үүсэж болох эрсдэлтэй зүйлс

Цахим орчинд хувийн мэдээлэл алдагдахад үүсэж болох хамгийн эрсдэлтэй зүйл юу болохыг тодруулахад 40% нь бусдыг хууран мэхлэх, залилах зорилгоор ашиглагдах, 39% нь хувийн мэдээллийг ашиглах, боловсруулах, бусдад дамжуулах байдлаар эрсдэл үүсэж болох юм гэж үзжээ. Насны бүлгээр авч үзвэл 36-45 насны 5 иргэн тутмын 2 нь мэдэгдэлгүйгээр хувийн мэдээллийг ашиглах, боловсруулах бусдад дамжуулах эрсдэл өндөр гэсэн байна.


Хүснэгт 4: Цахим орчинд хувийн мэдээлэл алдагдахад үүсэж болох эрсдэлүүд (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Миний хувийн мэдээллийг бусдыг хууран мэхлэх, залилах зорилгоор ашиглагдах	2	33%	129	41%	61	39%	13	42%	205	40%
Мэдэгдэлгүйгээр хувийн мэдээллийг ашиглах, боловсруулах бусдад дамжуулах	1	17%	121	38%	62	40%	12	39%	196	39%
Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учрах	1	17%	48	15%	19	12%	4	13%	72	14%
Бусдад буруугаар ойлгогдох, гадуурхагдах, нэр хүндээ алдах	2	33%	17	5%	13	8%	2	6%	34	7%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Цахим үйлчилгээ, нийгмийн сүлжээг ашиглахдаа нууцлалын мэдэгдлийг уншдаг эсэх

Цахим үйлчилгээ, нийгмийн сүлжээ ашиглахдаа тэдгээрийн нууцлалын мэдэгдлийг бүрэн уншиж танилцдаг хүн байхгүй харин судалгаанд оролцогчдын 70% нь хэсэгчлэн уншдаг гэжээ.

Зураг 3: Цахим үйлчилгээ, нийгмийн сүлжээг ашиглахдаа нууцлалын мэдэгдлийг уншдаг эсэх



Насны бүлгээр авч үзвэл 18-35 насныхан бусад насныхантай харьцуулахад хэсэгчлэн унших хандлага өндөр байна. Иргэд нас ахих тусам нууцлалын мэдэгдлийг уншихгүй байх нь ихсэж байна

Хүснэгт 5: Цахим үйлчилгээ, нийгмийн сүлжээг ашиглахдаа нууцлалын мэдэгдлийг уншдаг эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хэсэгчлэн уншдаг	3	50%	230	73%	104	67%	16	52%	353	70%
Огт уншдаггүй	3	50%	85	27%	51	33%	15	48%	154	30%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Цахим орчин дах хувийн мэдээллийн аюулгүй байдал хэнээс хамаарах вэ?

Судалгаанд хамрагдсан иргэдийн 74% нь цахим орчин дах хувийн мэдээллийн аюулгүй байдал хувь хүнээс өөрөөс нь хамаарна гэж үзэж байгаа бол 10% нь үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшил болон төрийн байгууллагаас хамаарна гэж үзэж байна. Харин 10 иргэн тутмын 1 нь төр, засгаас шалтгаална гэж үзэж байна.

Хүснэгт 6: Цахим орчин дах хувийн мэдээллийн аюулгүй байдал хэнээс хамаарах вэ? (Насны бүлгээр)


	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хувь хүнээс өөрөөс нь	4	67%	239	76%	115	74%	18	58%	376	74%
Үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшил болон төрийн байгууллага	0	0%	39	12%	12	8%	0	0%	51	10%
Төрөөс	0	0%	23	7%	15	10%	8	26%	46	9%
Мэдэхгүй	2	33%	14	4%	13	8%	5	16%	34	7%

Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%
------	---	------	-----	------	-----	------	----	------	-----	------

Хувийн мэдээллээ цахим орчинд хянаж чаддаг эсэх

Хувийн мэдээллээ цахим орчинд олон нийтэд нээлттэй байдлаар оруулсан тохиолдолд 33% нь мэдээлэлдээ бүрэн хяналт тавьж чаддаг бол 44% нь хяналт тавьж чаддаггүй гэжээ.

Зураг 4: Хувийн мэдээллээ цахим орчинд хянаж чаддаг эсэх



Насны бүлгээр авч үзвэл нас залуу болох тусам бүрэн хяналт тавьж чаддаг гэсэн иргэдийн хувь өндөр болж байна.

Хүснэгт 7: Хувийн мэдээллээ цахим орчинд хянаж чаддаг эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүрэн хяналт тавьж чаддаг	1	17%	123	39%	36	23%	6	19%	166	33%
Хяналт тавьж чаддаггүй	2	33%	122	39%	83	54%	16	52%	223	44%
Мэдэхгүй	3	50%	70	22%	36	23%	9	29%	118	23%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Нийгмийн сүлжээнд өөрийн хувийн нууцлалын тохиргоог сайжруулах оролдлого хийж байсан эсэх

Аливаа нийгмийн сүлжээний профайл дээрх үндсэн тохиргооноос хувийн нууцлалын тохиргоог өөрчилж сайжруулах оролдлого хийж байсан эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдагсдын 42% нь хувийн нууцлалын тохиргоог өөрчилж сайжруулах оролдлогыг хийж байгаагүй, тохиргоог хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй байна. Насны бүлгээр авч үзвэл залуучууд хувийн тохиргоог өөрчилж

байсан бол нас ахих тусам тохиргоог хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 8: Нийгмийн сүлжээнд өөрийн хувийн нууцлалын тохиргоог сайжруулах оролдлого хийж байсан эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хувийн нууцлалын тохиргоог өөрчилж байсан	4	67%	131	42%	55	35%	2	6%	192	38%
Хувийн нууцлалын тохиргоог өөрчилж сайжруулахыг оролддог	0	0%	53	17%	21	14%	0	0%	74	15%
Хувийн нууцлалын тохиргоог өөрчлөх амархан байдаг	0	0%	26	8%	2	1%	0	0%	28	6%
Хувийн нууцлалын тохиргоог өөрчлөх боломжгүй байдаг	1	17%	16	5%	17	11%	2	6%	36	7%
Тохиргоог хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй	1	17%	89	28%	60	39%	27	87%	177	35%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ХАНДАХ ХАНДЛАГА

Хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулалт хийхээс өмнө зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг тодруулахад нийт судалгаанд хамрагдагсдын 86% нь заавал зөвшөөрөл авах шаардлагатай гэсэн бол 10% нь шаардлагатай тохиолдолд л зөвшөөрөл авах нь зөв гэж үзэж байна.


Хүснэгт 9: Хувийн мэдээлэлд иргэдийн ашиглалт, хандалт, хамгаалалтад хандах хандлага (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Заавал зөвшөөрөл авах шаардлагатай	3	50%	270	86%	138	89%	25	81%	436	86%
Шаардлагатай тохиолдолд зөвшөөрөл авах нь зөв	3	50%	27	9%	15	10%	6	19%	51	10%
Эмзэг мэдээлэлтэй (эрүүл мэнд, бэлгийн чиг хандлага гэх мэт) холбоотой тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагатай	0	0%	14	4%	2	1%	0	0%	16	3%
Эмзэг мэдээлэлтэй холбоотой тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагатай	0	0%	4	1%	0	0%	0	0%	4	1%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад өгсөн хувийн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт итгэх итгэл


Судалгаанд хамрагдагсдын 46% нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад өгсөн хувийн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт итгэдэггүй байна.

Зураг 5: Хувийн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт итгэх итгэл



Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад өгсөн хувийн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт итгэдэг гэж хариулсан 275 иргэдээс аль байгууллагад илүү итгэдэг талаар тодруулахад 45% нь буюу банк, санхүүгийн байгууллагад өгсөн мэдээлэл хамгаалагдсан гэдэгт итгэх итгэл өндөр байна.

Зураг 6: Хувийн мэдээллийг хамгаалагдсан гэдэгт итгэх итгэл (Байгууллагын салбараар)



Доорх хүснэгтэд байгууллагуудад итгэх итгэлийг насны бүлгээр харууллаа.

Хүснэгт 10: Байгууллагуудад итгэх итгэл (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгдэд нь итгэдэг	2	50%	67	36%	19	29%	4	18%	92	33%
Төрийн байгууллагад итгэдэг	1	25%	58	32%	14	22%	6	27%	79	29%
Банк санхүүгийн байгууллагад итгэдэг	2	50%	72	39%	35	54%	14	64%	123	45%
Гар утасны операторуудад итгэдэг	0	0%	17	9%	8	12%	3	14%	28	10%
Эрүүл мэндийн байгууллагад итгэдэг	0	0%	40	22%	9	14%	3	14%	52	19%
Нийт	4		184		65		22		275	

Судалгаанд хамрагдсан 3 иргэн тутмын 2 нь төрийн болон хувийн байгууллагууд хувь хүний мэдээллийг зөвхөн дотоод үйл ажиллагаандаа ашигладаг гэдэгт итгэдэг бол 3 иргэн тутмын 1 нь хувийн мэдээллийг ямар зорилгоор цуглуулдагыг мэдэхгүй байна гэжээ.

Хүснэгт 11: Төрийн болон хувийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цуглуулдаг зорилгыг мэдэх эсэх (Насны бүлгээр)

18 хүртэл	18-35 хүртэл	36-45 хүртэл	46-с дээш	Нийт
-----------	--------------	--------------	-----------	------

	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зөвхөн дотоод үйл ажиллагаандаа ашигладаг гэж итгэдэг	4	67%	211	67%	102	66%	22	71%	339	67%
Мэдэхгүй	2	33%	104	33%	53	34%	9	29%	168	33%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Иргэд хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглахыг огт зөвшөөрөхгүй байна.


Хүснэгт 12: Хувийн мэдээллийн анх авсан зорилгоос өөр зорилгоор ашиглахыг зөвшөөрөх эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зөвшөөрнө	0	0%	3	1%	2	1%	0	0%	5	1%
Огт зөвшөөрөхгүй	6	100%	304	97%	153	99%	30	97%	493	97%
Мэдэхгүй	0	0%	8	3%	0	0%	1	3%	9	2%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Хувийн мэдээлэл нь ямар нэгэн байдлаар алдагдах, ил болох тохиолдол тулгарч байсан эсэх

Судалгаанд хамрагдсан иргэдийн 14%-д хувийн мэдээлэл нь ямар нэг байдлаар алдагдах, ил болох асуудал тулгарч байжээ.

Зураг 7: Хувийн мэдээлэл нь ямар нэгэн байдлаар алдагдах, ил болох тохиолдол тулгарч байсан эсэх



Насны бүлгээр харвал залуу насны бүлэгт хувийн мэдээлэл алдагдах, ил болох тохиолдол бусад бүлгүүдтэй харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 13: Хувийн мэдээлэл нь ямар нэгэн байдлаар алдагдах, ил болох тохиолдол тулгарч байсан эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	0	0%	48	15%	21	13%	3	10%	72	14%
Үгүй	5	83%	217	69%	99	64%	27	87%	348	69%
Мэдэхгүй	1	17%	50	16%	35	23%	1	3%	87	17%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Хувийн мэдээллээ алдсан тохиолдолд хаана хандах вэ?

Хувийн мэдээллээ алдсан тохиолдолд хаана хандахыг тодруулахад 72% нь цагдаагийн байгууллагад хандана гэсэн бол 20% нь хаана хандахаа мэдэхгүй байна.


Хүснэгт 14: Хувийн мэдээллээ алдсан тохиолдолд хаана хандах талаар (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Цагдаагийн байгууллага	2	33%	226	72%	115	74%	21	68%	364	72%
Хүний эрхийн үндэсний комисс	0	0%	30	10%	8	5%	4	13%	42	8%
Мэдэхгүй	4	67%	59	19%	32	21%	6	19%	101	20%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Төрийн болон хувийн байгууллагуудад хадгалагдаж буй хувийн мэдээллээ устгуулж байсан эсэх

Судалгаанд хамрагдсан иргэдийн 87% нь төрийн болон хувийн байгууллагуудад хадгалагдаж буй хувийн мэдээллээ устгуулж байгаагүй гэж хариулжээ.

Зураг 8: Хувийн мэдээлэл нь устгагдаж байсан эсэх



Насны бүлгээр доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 15: Хувийн мэдээлэл устгагдаж байсан эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	0	0%	23	7%	7	5%	0	0%	30	6%
Үгүй	6	100%	266	84%	136	88%	31	100%	439	87%
Мэдэхгүй	0	0%	26	8%	12	8%	0	0%	38	7%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах шаардлагатай эсэх

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл шаардлагатай эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан бүх иргэд ямар нэг байдлаар зөвшөөрөл шаардлагатай гэсэн бол 25% нь заавал бичгээр зөвшөөрлийг авах шаардлагатай гэсэн байна.

Хүснэгт 16: Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авах шаардлагатай эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	2	33%	215	68%	109	71%	22	71%	349	69%
Заавал бичгээр авах шаардлагатай	1	17%	79	25%	40	26%	8	26%	128	25%
Зарим тохиолдолд шаардлагатай	3	50%	21	7%	5	3%	1	3%	30	6%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Хувийн мэдээллийг тусгайлсан хуулиар хамгаалах шаардлагатай эсэх

Хувийн мэдээллийг тусгайлсан хуулиар хамгаалах шаардлагатай эсэхийг тодруулахад 92% нь тусгайлсан хууль шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 17: Хувийн мэдээллийг тусгайлсан хуулиар хамгаалах шаардлагатай эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Мэдэхгүй	2	33%	18	6%	8	5%	1	3%	28	6%
Тийм	4	67%	290	92%	143	92%	28	90%	465	92%
Үгүй	0	0%	7	2%	4	3%	2	6%	13	3%

Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%
------	---	------	-----	------	-----	------	----	------	-----	------

Хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай эсэх

Хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай эсэхийг тодруулахад 64% нь байх шаардлагатай гэж үзэж байна. Харин 15% нь ийм байгууллага байх шаардлагагүй гэж үзжээ. Насны бүлгээр авч үзвэл залуучууд тухайн байгууллага байх шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 18: Хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	2	33%	207	66%	96	62%	17	55%	322	64%
Мэдэхгүй	4	67%	64	20%	35	23%	5	16%	109	21%
Үгүй	0	0%	44	14%	23	15%	9	29%	76	15%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Нийтийн эзэмшлийн гудамж талбайн дүрс бичлэгийн төхөөрөмжийн талаарх иргэдийн санаа бодол

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулдаг шалтгааныг иргэд хэрхэн ойлгож байгаа тодруулахад 10 иргэн тутмын 9 нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байршуулдаг гэсэн бол 10 иргэн тутмын 1 нь мэдэхгүй, сонирхож байгаагүй гэж хариулжээ.

Хүснэгт 19: Нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийг төхөөрөмж байршуулж буй шалтгааныг хэрхэн ойлгодог ойлголт (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2	33%	280	89%	147	95%	30	97%	459	91%
Мэдэхгүй	1	17%	22	7%	3	2%	0	0%	26	5%
Сонирхож байгаагүй юм байна	3	50%	13	4%	5	3%	1	3%	22	4%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Судалгаанд оролцогчдын 76% нь нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах нь зөв зүйтэй гэж үзэж байна. Харин 10 хүн

тутмын 1 нь нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах нь буруу гэж үзэж байна.

Хүснэгт 20: Нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах нь зөв эсэх (Насны бүлгээр)

	18 хүртэл		18-35 хүртэл		36-45 хүртэл		46-с дээш		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зөв	4	67%	237	75%	121	78%	25	81%	387	76%
Буруу	1	17%	28	9%	13	8%	3	10%	45	9%
Мэдэхгүй	1	17%	50	16%	21	13%	3	10%	75	15%
Нийт	6	100%	315	100%	155	100%	31	100%	507	100%

Судалгааны үр дүн:

Судалгааны үр дүнгээс харвал иргэдэд хувийн мэдээллээ хамгаалах талаар дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1. Төрийн байгууллагууд иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ тэднээс нэмэлт хувийн мэдээлэл өгөхийг шаарддаг бөгөөд үйлчилгээ авахын тулд өөрийн хувийн мэдээллийг өгөхөөс өөр сонголт байдаггүй байна.
2. Цахим орчинд хувь хүний мэдээллийг хууран мэхлэх, залилах зорилгоор ашиглах, тухайн хувь хүний мэдээллийг эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах цаашлаад тэдгээр хүмүүсийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Иргэд цахим үйлчилгээг ашиглахдаа нууцлалын мэдэгдлийг бүрэн уншиж танилцдаггүй бөгөөд иргэд өөрийн хувийн мэдээллийн нууцлал, хамгааллыг сайжруулах талаар мэдлэг ойлголтгүй байна.
4. Судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь өөрийн хувийн мэдээллээ хамгаалах нууцлал, аюулгүй байдлыг хангах асуудал нь хувь хүнээс өөрөөс нь бүрэн хамаарна гэж үзэж байна.
5. Иргэд хувийн мэдээллээ цахим орчинд олон нийтэд нээлттэй байдлаар оруулсан тохиолдолд мэдээлэлдээ бүрэн хяналт тавьж чаддаггүй байна.
6. Иргэд хувийн нууцлалын тохиргоогоо өөрчилж сайжруулах оролдлогыг хийж байгаагүй, тохиргоог хэрхэн өөрчлөхийг мэдэхгүй байна.
7. Иргэд өөрийнх нь хувийн мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор зөвшөөрөлгүйгээр дахин ашиглахыг огт зөвшөөрөхгүй гэсэн бөгөөд хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулалт хийхээс өмнө өөрөөс нь заавал зөвшөөрөл авах шаардлагатай гэж үзсэн байна.
8. Иргэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад өгсөн хувийн мэдээлэл нь хамгаалагдсан гэдэгт итгэдэггүй, эргэлздэг байна.
9. Хувийн мэдээлэл нь алдагдах, ил болох тохиолдол иргэдэд тулгардаг ба хувийн мэдээллээ алдсан тохиолдолд судалгаанд хамрагсдын дийлэнх нь цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ гэсэн байна.

10. Төрийн болон хувийн байгууллагуудад хадгалагдаж буй хувийн мэдээллээ устгуулж байгаагүй гэж хариулжээ.
11. Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл шаардлагатай гэж үзсэн байна.
12. Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь нийтийн эзэмшлийн гудамж талбайд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах нь зөв гэж үзэж байгаа бөгөөд дүрс бичлэгийн төхөөрөмж байрлуулдаг шалтгааныг зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой гэсэн ойлголттой байна.
13. Судалгаанд хамрагдсан иргэд хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай ба хувийн мэдээллийг хамгаалах талаар тусгайлсан хууль батлах нь зүйтэй гэж үзсэн байна.

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛЛЫН ТАЛААР БАЙГУУЛЛАГААС АВСАН СУДАЛГАА

“Монгол Өмгөөлөгч” ХХН-ийн зүгээс хувь хүний мэдээлэл цуглуулдаг, хадгалдаг, боловсруулалт хийдэг байгууллагуудаас хувь хүний мэдээлэл хамгааллын талаар 7 асуултын хүрээнд цахим хэлбэрээр судалгаа авсан болно.

Судалгаанд нийт 101 байгууллага хамрагдсанаас 14 эмнэлэг, 7 интернэтийн үйлчилгээ үзүүлэгч, 4 үүрэн холбооны оператор компани, 10 банк, бусад хувь хүний мэдээлэл, цуглуулдаг, хадгалдаг төрийн болон бусад үйлчилгээний 66 байгууллага байна.

Байгууллагаас авсан судалгааны анкетын загвар:

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ САНАЛ АСУУЛГА

Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Энэхүү санал асуулгын зорилго нь Монгол Улсад хувь хүний мэдээллийг хамгаалах, цуглуулах, боловсруулах, ашиглах тулгарч буй асуудлуудыг тодруулахад оршино.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж энэхүү судалгааг үнэн зөв бөглөж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсье.

ХЭСЭГ I. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Компанийн үйл ажиллагааны чиглэл:

- а. Үүрэн холбооны оператор компани
- б. Банк
- в. Эмнэлэг
- г. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч
- д. Бусад үйлчилгээ

ХЭСЭГ II. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ, ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТ

1. Танай байгууллага хувь хүний мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны хүрээнд хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журамтай юу?
 - а. Тийм
 - б. Үгүй
 - в. Бусад журамд оруулж зохицуулсан
2. Танай байгууллага хувь хүний мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэг үү?
 - а. Хувийн мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэг
 - б. Өөр ангилалд хуваадаггүй бүх төрлийн хувийн мэдээллийг ижил төвшинд авч үздэг
3. Танай байгууллага хувь хүнээс түүнд хамаарах мэдээллийг цуглуулахаас өмнө мэдээллийг ашиглах болсон зорилго, зорилтоо тодорхойлсон байдаг уу?
 - а. Тийм
 - б. Үгүй
4. Танай байгууллага хувь хүний мэдээллийг хил дамнуулан бусдад дамжуулахыг зөвшөөрдөг үү?
 - а. Тийм
 - б. Үгүй
5. Танай байгууллага хувь хүнээс цуглуулсан хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж мөрддөг үү?
 - а. Тийм
 - б. Үгүй
6. Хувь хүний талаар цуглуулж буй болон хадгалж, боловсруулалт хийж буй хувь хүний мэдээллийг хамгаалах талаар өөрийн ажилчдад сургалт зохион байгуулдаг уу?
 - а. Тийм
 - б. Үгүй
7. Танай байгууллага мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал хамгаалал хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэнтэй юу?
 - а. Тийм
 - б. Үгүй

ТАНД БАЯРЛАЛАА

БАЙГУУЛЛАГААС АВСАН СУДАЛГАА

СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Доорх зурагт судалгаанд хамрагдсан байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг харууллаа.


Зураг 9: Судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл



ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫН БОДЛОГО, ДҮРЭМ, ЖУРАМТАЙ ЭСЭХ

Нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын 84% нь хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журмыг зохицуулсан зохицуулалт байгаагаас 25% нь бусад журамд оруулж зохицуулсан байна.

Зураг 10: Хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журамтай эсэх



Хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журамтай эсэхийг байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 21: Хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журамтай эсэх (Байгууллагын үйл ажиллагааны салбараар)

	Эмнэлэг		Банк		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч		Үүрэн холбооны оператор компани		Бусад үйлчилгээ		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Тийм	12	86%	10	100%	4	57%	4	100%	30	45%	60
Бусад журамд оруулж зохицуулсан	2	14%	0	0%	0	0%	0	0%	14	21%	16
Үгүй	0	0%	0	0%	3	43%	0	0%	22	33%	25
Нийт	14	100%	10	100%	7	100%	4	100%	66	100%	101

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ “ЭМЗЭГ” АНГИЛАЛД ЯЛГАН ХУВААЖ АВЧ ҮЗДЭГ ЭСЭХ

Судалгаанд хамрагдсан 10 байгууллага тутмын 7 нь хувь хүний мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэггүй. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон банкнууд хувийн мэдээллийг эмзэг ангилалд ялгах хандлага бусад салбарын байгууллагуудтай харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 22: “Эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэг эсэх (Байгууллагын үйл ажиллагааны салбараар)


	Эмнэлэг		Банк		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч		Үүрэн холбооны оператор компани		Бусад үйлчилгээ		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Өөр ангилалд хуваадаггүй бүх төрлийн хувийн мэдээллийг ижил төвшинд авч үздэг	10	71%	5	50%	3	43%	3	75%	48	73%	69	68%
Хувийн мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэг	4	29%	5	50%	4	57%	1	25%	18	27%	32	32%
Нийт	14	100%	10	100%	7	100%	4	100%	66	100%	101	100%

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ ЗОРИЛГО, ЗОРИЛТОО ТОДОРХОЙЛДОГ ЭСЭХ, ХИЛ ДАМНУУЛАН БУСДАД ДАМЖУУЛДАГ ЭСЭХ

Судалгаанд хамрагдсан 10 байгууллага тутмын 3 нь хувь хүний мэдээллийг цуглуулахдаа хэрхэн ашиглах зорилго, зорилтоо тодорхойлоогүй байдаг бол 10

байгууллага тутмын 1 нь хил дамнуулан бусдад дамжуулдаг байна. Ялангуяа интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хувь хүний мэдээллийг хил дамнуулан бусдад дамжуулдаг гэжээ.

Зураг 11: Хувийн мэдээллийг ашиглах зорилго, зорилтоо тодорхойлсон эсэх, хил дамнуулан бусдад дамжуулдаг эсэх



Дээрх асуултуудыг судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааны салбараар доорх хүснэгтэд үзүүллээ.


Хүснэгт 23: Хувийн мэдээллийг ашиглах зорилго, зорилтоо тодорхойлсон эсэх, хил дамнуулан бусдад дамжуулдаг эсэх (Байгууллагын үйл ажиллагааны салбараар)

	Эмнэлэг		Банк		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч		Үүрэн холбооны оператор компани		Бусад үйлчилгээ		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Хувийн мэдээллийг ашиглах зорилго, зорилтоо тодорхойлсон эсэх											
Тийм	6	43%	10	100%	6	86%	4	100%	44	67%	70
Үгүй	8	57%	0	0%	1	14%	0	0%	22	33%	31
Хувь хүний мэдээллийг хил дамнуулан бусдад дамжуулдаг эсэх											
Тийм	0	0%	0	0%	2	29%	0	0%	6	9%	8
Үгүй	14	100%	10	100%	5	71%	4	100%	60	91%	93
Нийт	14	100%	10	100%	7	100%	4	100%	66	100%	101

**ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАДГАЛАХ НӨХЦӨЛ БОЛОН ХУГАЦААГ
ТОДОРХОЙЛЖ МӨРДДӨГ ЭСЭХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭСЭХ**

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 59 байгууллага буюу 58% нь хувь хүнээс цуглуулсан хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж дагаж мөрддөг. Харин хувь хүний талаар цуглуулж буй болон хадгалж, боловсруулалт хийж буй мэдээллийг хамгаалах талаарх сургалтыг 48 байгууллага буюу 48% нь өөрсдийн ажилчдад зохион байгуулдаг.

Зураг 12: Хувийн мэдээллийг хадгалах нөхцөл, хугацааг тодорхойлж мөрддөг эсэх, компанийн ажилтнуудад хувь хүний мэдээллийг хамгаалах талаар сургалт өгдөг эсэх



Хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж мөрддөг эсэх



Хувь хүний мэдээллийг хамгаалах талаар өөрийн ажилчдад сургалт зохион байгуулдаг эсэх

Дээрх асуултуудыг судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааны салбараар доорх хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 24: Хувийн мэдээллийг хадгалах нөхцөл, хугацааг тодорхойлж мөрддөг эсэх, компанийн ажилтнуудад хувь хүний мэдээллийг хамгаалах талаар сургалт өгдөг эсэх (Байгууллагын үйл ажиллагааны салбараар)

	Эмнэлэг		Банк		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч		Үүрэн холбооны оператор компани		Бусад үйлчилгээ		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж мөрддөг эсэх											
Тийм	6	43%	8	80%	5	71%	4	100%	36	55%	59
Үгүй	8	57%	2	20%	2	29%	0	0%	30	45%	42
Хувь хүний мэдээллийг хамгаалах талаар өөрийн ажилчдад сургалт зохион байгуулдаг эсэх											
Тийм	2	14%	10	100%	6	86%	2	50%	28	42%	48
Үгүй	12	86%	0	0%	1	14%	2	50%	38	58%	53
Нийт	14	100%	10	100%	7	100%	4	100%	66	100%	101

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, ХАМГААЛАЛ ХАРИУЦСАН БҮТЭЦ ЭСВЭЛ МЭРГЭЖИЛТЭНТЭЙ ЭСЭХ

Судалгаанд хамрагдсан 2 байгууллага тутмын 1 нь мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал хамгаалалтыг хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэнтэй байна.

Үйл ажиллагааны салбараар харвал үүрэн холбооны оператор компаниуд болон интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд бусад салбартай харьцуулахад мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал хамгаалалтыг хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэнтэй байна.

Хүснэгт 25: Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал хамгаалал хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэнтэй эсэх (Байгууллагын үйл ажиллагааны салбараар)

	Эмнэлэг		Банк		Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч		Үүрэн холбооны оператор компани		Бусад үйлчилгээ		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	2	14%	7	70%	6	86%	3	75%	28	42%	46	46%
Үгүй	12	86%	3	30%	1	14%	1	25%	38	58%	55	54%
Нийт	14	100%	10	100%	7	100%	4	100%	66	100%	101	100%

Судалгааны үр дүн:

Дээрх судалгааны үр дүнгээс харвал нийт судалгаанд хамрагдсан байгууллагуудын дийлэнх хувь нь хувь хүний мэдээллийн нууцлалтай холбоотой харилцааг зохицуулсан бодлого, дүрэм, журамтай байна. Үүнээс банк, эмнэлэг болон үүрэн холбооны оператор байгууллагууд хувь хүний мэдээллийн нууцлалын бодлого, дүрэм, журамтай байгаа нь бусад салбарын байгууллагуудтай харьцуулахад өндөр байна.



Харин судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн байгууллагуудад хувь хүний мэдээллийг хамгаалах талаар дараах асуудал тулгарч байна. Үүнд:

1. Судалгаанд хамрагдсан дийлэнх байгууллага хувь хүний мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хуваадаггүй бүх төрлийн хувийн мэдээллийг ижил төвшинд авч үздэг;
2. Хувь хүний мэдээллийг ашиглах зорилго, зорилтоо тодорхойлдоггүй, хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж мөрддөггүй;
3. Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тухайд хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хил дамнуулан бусдад дамжуулдаг;
4. Дийлэнх эмнэлэг болон бусад үйлчилгээний байгууллагууд мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлал хамгааллыг хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэн байддаггүй байна.

ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБОГДОН ГАРЧ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Монгол Улсад хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдлыг судлан тогтоох зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс сүүлийн 3 жилийн байдлаар тайлан, мэдээллийг Эрүүгийн хуулийн тусгай анги (ЭХТА)-д зааснаар нарийвчлан авсан билээ. Түүнчлэн энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын тайлангаас өмнөх жилүүдийн тоон мэдээллийг авч нэгтгэсэн болно.

Хүснэгт 1. Цагдаагийн байгууллагад хувь хүний мэдээлэлтэй холбоотой хүлээн авсан гомдол, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл¹³



¹³ Цагдаагийн байгууллагад 2018, 2019 он, 2020 оны эхний 11 сарын байдлаар хүлээж авсан тодорхой төрлийн гомдол мэдээллийн бүртгэл

Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан дээрх гомдол, мэдээллээс дараагийн шатанд буюу Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зарим гэмт хэргийг эцэслэн шийдэгдсэн¹⁴ байдлыг авч үзвэл:

Д.д	Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	
		2018 он	2019 он
1	10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	0	2
2	13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах	0	2
3	13.11 дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах	1	1
4	13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах	0	0
5	17.1 дүгээр зүйл. Хулгайлах	1553	1671
6	17.2 дугаар зүйл. Дээрэмдэх	301	316
7	17.11 дүгээр зүйл. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	6	4
8	23.2 дугаар зүйл. Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	14	28
9	23.3 дугаар зүйл. Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух	0	1
	13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах гэмт хэрэг	3	2
10	Зөрчлийн тухай хууль 6.21 дүгээр зүйл Гүтгэх	1	1
11	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянасан	32	44
12	Хүнээс	Хэвээр	19
13		Өөрчлөлт оруулсан	7
14		Хүчингүй болгосон	18

Уг судалгаанаас харвал хувь хүний мэдээлэл алдагдах улмаар эд хөрөнгө, нэр хүнд, амь насанд хүртэл хохирол учрах тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа хэдий ч шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдэж байгаа хэргүүд нь нийт гэмт хэргийн тоотой харьцуулахад харьцангуй цөөн байна.

Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6.21 дүгээр зүйлд зааснаар гүтгэх гэдгийг хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан гэж тодорхойлжээ. Дээрх хууль батлагдсанаар хүний нэр төр, алдар хүндийн эсрэг үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болж харин зөрчилд тооцохоор болсон.

¹⁴ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2020-12-16-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зарим гэмт хэргийн тоон мэдээлэл /2018-2019 он/-ийг цахимаар ирүүлсэн болно.

2017 оны 7 дугаар сараас хойш Зөрчлийн тухай хуулийн “гүтгэх” /6.21 дүгээр зүйл/ зөрчил буюу хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан 111 зөрчил бүртгэгдсэн ба үүнээс 91 тохиолдлыг хэрэгсэхгүй болгосон бол 20 тохиолдлыг зөрчилд тооцож /шийтгэврээр торгосон/ хариуцлага тооцсон байна. /Зураг 1-ийг үзнэ үү/.¹⁵

Зураг 1. Зөрчлийн тухай хууль /6.21 дүгээр зүйл. Гүтгэх/ 2017.07.01-ээс¹⁶, /тоон утгаар/



Дээр дурдсанчлан “гүтгэх”, “доромжлох” үйлдлийг урьд нь 2002 оны Эрүүгийн хуулийн Доромжлох буюу “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон” /110 дугаар зүйл/, Гүтгэх буюу “Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан” /111 дүгээр зүйл/ гэсэн зүйлээр тус тус зохицуулж байсан.


Энэхүү хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг буюу доромжлох, гүтгэх хэргийн тоон үзүүлэлтийг 2011-2016 оны байдлаар авч үзье. /Зураг 2-ыг үзнэ үү/.

Зураг 2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110, 111 дүгээр зүйлээр бүртгэгдсэн гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлт /2011-2016 он/¹⁷

¹⁵ Дам эшлэв. Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/, Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 он, 11-13 дахь тал

¹⁶ Мөн тэнд

¹⁷ Мөн тэнд



Энэхүү тоон үзүүлэлтээс харвал 2011-2016 оны хооронд “доромжлох” гэмт хэрэг нийтдээ 74 бүртгэгдсэн ба нэг жилд дунджаар 12 гэмт хэрэг бүртгэгддэг байна. Үүний 6-7 орчим хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн бол 5-6 орчим хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн байна.

Гүтгэх хэрэг нийтдээ 144 бүртгэгдсэн ба жилд дунджаар 12 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар прокурорт шилжүүлсэн бол 11 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ.

Гэтэл Зөрчлийн тухай хуулийг мөрдөж эхэлснээс хойш хагас жил хүрэхгүй хугацаанд “гүтгэх” зөрчил 111 бүртгэгдсэн нь энэ хугацаанд дунджаар 22 зөрчил бүртгэгдсэн байгаа нь анхаарал татаж байна. /Үүнээс 18 хувь нь шийтгэврээр торгож, 82.0 хувь нь хэрэгсэхгүй болсон байна/.

Эдгээр судалгаануудыг нэгтгэн дүгнэвэл хувийн мэдээллийг хамгаалах талаар дараах нийтлэг асуудал тулгарч байна. Үүнд:

- 1) Хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, боловсруулах;
- 2) Бусдын хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр ашиглах, боловсруулах;
- 3) Хувийн мэдээлэл бусдад алдагдах эсвэл хулгайлагдах;
- 4) Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд ил болгох, тараах;
- 5) Өөрийн хувийн мэдээлэлд хандах тэдгээрийг засварлах боломжгүй байх;
- 6) Хувийн эмзэг мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглах, боловсруулах;

Мөн Хувь хүний нууцын тухай хууль хэт ерөнхий зохицуулалттай тул эдгээр асуудлыг бүрэн хэмжээнд зохицуулдаггүй, хувь хүний мэдээллийг хамгаалах талаар тусгайлсан хууль байхгүй зэрэг болно.

1.2. ТУХАЙН АСУУДЛААР ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛ НЬ ХӨНДӨГДӨЖ БАЙГАА НИЙГМИЙН БҮЛЭГ, ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БУСАД ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийг шинээр боловсруулж баталснаар эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй дараах бүлгүүдийг тодорхойлов. Үүнд: Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн болон бизнесийн байгууллага, иргэн, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон олон улсын байгууллага. Эдгээр бүлгүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөнө гэж үзэж байна. Үүнд: тухайн байгууллага, хувь хүний үйл ажиллагаа, дүрэм журам болон хүний нөөцөд орох өөрчлөлтүүдийг багтаасан болно.

Хүснэгт 2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1. Төр/төрийн байгууллага, албан тушаалтан	Хуульд заасан үндэслэл байхгүй бол хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалалт хийх төрийн байгууллагууд хувь хүнээс заавал зөвшөөрөл авсны үндсэн дээр хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагаандаа хувь хүний мэдээллийг ашиглах тохиолдолд хувь хүнээс заавал зөвшөөрөл авах талаар өөрчлөлт орно.
2. Хувийн байгууллага	Хуульд заагаагүй бол хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад заавал хувь хүнээс зөвшөөрөл авсны үндсэн дээр хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах эрх үүснэ. Үйл ажиллагаандаа хувь хүний мэдээллийг ашиглах тохиолдолд хувь хүнээс заавал зөвшөөрөл авах талаар өөрчлөлт орно.
3. Төрийн бус байгууллага	Хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх, ашиглах тэдгээрт дүгнэлт хийх, статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийдэг төрийн бус байгууллагууд хувь хүнээс зөвшөөрөл авах, хийж буй судалгааны зорилго, ямар боловсруулалт хийх, хэрхэн ашиглах, ямар үр дүнд хүрэх талаар зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгаа хийх боломжтой болно. Үйл ажиллагаандаа хувь хүний мэдээллийг ашиглах тохиолдолд хувь хүнээс заавал зөвшөөрөл авах талаар өөрчлөлт орно.
4. Иргэн	Иргэд цахим халдлага болон хулгай дээрэмд өртөж өөрийн хувийн мэдээллийг алдах тохиолдол их гарч байна. Улмаар хувийн мэдээлэл нь буруу зорилгоор бусдад ашиглагдах, нэр хүнд, эрүүл мэнд, амь насанд аюул занал учирч болох эрсдэл үүсэж байна. Иймд хувь хүн болон иргэд өөрт хамаарах хувийн мэдээллийг бусдад өгөхдөө ямар үндэслэл зорилгоор, ямар хугацаанд, ямар үр дүнд хүрэх гэж авч байгаа

		талаар танилцаж тусгайлан зөвшөөрөл өгнө. Мөн зөвшөөрөл өгөхгүй байж болох ба энэ тохиолдолд ямар бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамрагдах боломж үүсэхгүй байх талаар мэдээллээр мөн хангагдана. Хувь хүний мэдээлэл хамгаалагдах улмаар хувь хүний эрхийг хамгаалах боломж бүрдэнэ. Тухайн иргэнээс зөвшөөрөл авдаг болно.
5.	Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага	Хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулалт хийх, ашиглах тэдгээрт дүгнэлт, статистик мэдээлэл бэлтгэх болон судалгаа шинжилгээ хийдэг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд хувь хүнээс зөвшөөрөл авах, хийж буй судалгааны зорилго, ямар боловсруулалт хийх, хэрхэн ашиглах, ямар үр дүнд хүрэх талаар зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгаа хийх боломжтой болно. Үйл ажиллагаандаа хувь хүний мэдээллийг ашиглах тохиолдолд хувь хүнээс заавал зөвшөөрөл авах талаар өөрчлөлт орно.
6.	Олон улсын байгууллага	Олон улсын байгууллагууд Монгол улсын иргэний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах мөн хилийн чанадад дамжуулах зэрэгт мөн тухайн хувь хүн буюу иргэнээс зөвшөөрөл авах, тухайн хил дамжуулж буй улс орон нь хувь хүний мэдээлэл хамгаалах талаар хууль тогтоомжтой байх тухай шаардлага тавигдана. Үйл ажиллагаандаа хувь хүний мэдээллийг ашиглах тохиолдолд хувь хүнээс заавал зөвшөөрөл авах талаар өөрчлөлт орно.

1.3. ТУХАЙН АСУУДАЛ ҮҮССЭН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Монгол Улсад хувь хүний мэдээллийг хамгаалах үйл ажиллагаанд үүсэж буй тулгамдсан асуудлуудыг зохицуулах хувилбарыг дараах асуудал бүрээр харьцуулан үзэв.

Хүснэгт 3. Хувь хүний мэдээллийг хамгаалах талаар тулгарч буй асуудлууд

№	Асуудал	Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл
1	Анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах	Иргэд гар утасны дугаар болон цахим хаягаа бүртгүүлээгүй үед иргэдийн гар утас болон имэйл хаягаар хүсээгүй зар сурталчилгаа, мессеж, имэйл, дуудлага илгээх тохиолдлууд их байна.
2	Хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр цуглуулах, боловсруулах, ашиглах	Хувь хүний мэдээллийг нийгмийн сүлжээ, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болгох асуудал гарч байна.
3	Хувь хүний мэдээлэл алдагдах эсвэл хулгайлагдах	Цахим халдлагад өртөх эсвэл хулгайлагдах замаар хувийн мэдээлэл алдагдсанаар нийгэмд гадуурхагдах, гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдэж байна.
4	Хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ил болгох	Хувийн мэдээлэл нь ил болсноор тухайн хүнд учирсан ёс суртахууны гэм хорыг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн тохиолдол цөөн байна.
5	Өөрийн хувийн мэдээлэлд хандах боломжгүй байх	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах, алдаатай хувийн мэдээллийг засах, устгуулах боломжгүй байна.
6	Хувь хүний эмзэг мэдээллийг боловсруулах	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хувааж авч үздэггүй. Хувь хүний эмзэг мэдээлэл болох үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, эрүүл мэндийн болон бэлгийн чиг хандлага болон бэлгийн амьдрал зэрэг мэдээллийг бусдад дамжуулах, ил болгосноор тухайн хүнийг гутаан доромжлох, дарамтлах, айлган сүрдүүлэх улмаар амиа хорлоход хүргэх тохиолдлууд нэмэгдэж байна.

Хувь хүний мэдээлэл хамгаалах харилцаанд Хувь хүний нууцын тухай хуулийг хэрэглэхэд зохицуулалтын агуулга нь хэт явцуу тул дээр дурдсаны дагуу хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор боловсруулах, ашиглах, зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр цуглуулах, боловсруулах, ашиглах, хувь хүний мэдээлэл алдагдах эсвэл хулгайлагдах, хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ил болгох, хувь хүн өөрийн хувийн мэдээлэлд

хандах боломжгүй байх, хувь хүний эмзэг мэдээллийг боловсруулах зэрэг тулгарч буй асуудал үүсэхэд дээрх асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна.

Түүнчлэн өөрийн хувийн мэдээллийг өгч буй хувь хүн болон хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээд хоорондын эрх зүйн харилцааг цогцоор нь зохицуулсан хууль байхгүй, эрх олгосон, зөвшөөрсөн, хориглосон үйл ажиллагааг нарийвчлан зохицуулаагүй байгаа нь хувь хүний мэдээлэлтэй холбоотой тулгарч буй асуудал шийдвэрлэгдэхгүй байх нөхцөл байдалд хүрч байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ НЬ

Өмнөх хэсэг болох асуудлын дүн шинжилгээнээс гарсан дүгнэлтийг багцлан хувь хүний мэдээлэл хамгаалахад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар томьёолж байна. Үүнд:

“Монгол Улсад хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах харилцааг цогцоор нь зохицуулах, хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбогдуулан төр, байгууллага, иргэн хоорондын харилцаа, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох замаар хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангах улмаар хувь хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлэх”.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг тогтоох;

2. Хувь хүний мэдээлэл цуглуулахдаа мэдээллийг тээгч буюу эзнээс зөвшөөрөл авах, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журмыг тогтоох;

3. Хувь хүн буюу мэдээллийн эзэн, хувь хүний мэдээлэл хариуцагч болон боловсруулагчийн эрх, үүргийг хуульчлах;


4. Хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглахад хязгаар тогтоох, хувь хүний мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайтар бүрдүүлэх;

5. Хувь хүний мэдээлэл хамгаалах талаар аюулгүй байдлын арга хэмжээ авах, зөрчлийг мэдэгдэх, нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалтыг бий болгох;

6. Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагыг тогтоож, хуулийн хэрэгжилтийг хянаж ажиллах чиг үүргийг тодорхой болгох;

7. Хувь хүний мэдээллийг хууль бусаар боловсруулахыг хориглох үйл ажиллагааг тогтоон хуульчлах;

8. Хувь хүний мэдээллийг хууль бусаар ашигласан, задруулсны улмаас тухайн хүнд учруулсан ёс суратахууны гэм хорыг нөхөн төлөх талаар тодрхой зохицуулах.



ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ОЛЖ ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Энэхүү тайлангийн 1.4 дэх хэсэгт заасан асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч харьцуулан авч үзвэл:

Хүснэгт 4: Асуудал 1 - Анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор хувь хүний мэдээллийг боловсруулах

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1. “Тэг” хувилбар	Анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор хувийн мэдээллийг боловсруулах, гуравдагч этгээдэд дамжуулах улмаар зах зээлээ өргөтгөх маркетинг хийх нөхцөлийг бүрдүүлэх эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх байдал үргэлжилнэ.	Зардал нэмэгдэхгүй боловч үүссэн асуудал шийдвэрлэгдэхгүй.	Үр дүнгүй
2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод богино хугацаанд, шууд хүрэх боломжгүй. Иргэдийг соён гэгээрүүлж болох боловч хувь хүний мэдээллийг боловсруулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд сурталчилгаа хийх замаар нөлөөлөх боломжгүй. Мөн хувийн мэдээллийг хамгаалах тогтолцоо бий болж чадахгүй.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй юм.	Үр дүн хангалттай бус
3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4. Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6. Захиргааны шийдвэр гаргах	Эрх зүйн тодорхой үндэслэл байхгүй тул захиргааны шийдвэр гаргах боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7. Хууль тогтоомжийн төсөл	Хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр хэлбэрээр ашиглахыг хориглох	Зардал нэмэгдэхгүй боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй

	боловсруулах	шаардлагатай. Мөн хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулан иргэдийн хүсээгүй зар сурталчилгаа, имэйл, мессеж илгээж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнд хүлээлгэх хариуцлагыг хуулиар зохицуулснаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.		
--	--------------	---	--	--

Хүснэгт 5: Асуудал 2 - Бусдын хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр боловсруулах

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Бусдын мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр боловсруулах, нийгмийн сүлжээ, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болгох улмаар хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх байдал үргэлжилнэ.	Зардал нэмэгдэхгүй мөн үүссэн асуудал шийдэгдэхгүй	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод богино хугацаанд, шууд хүрэх боломжгүй. Иргэдийг соён гэгээрүүлж болох боловч хувь хүний мэдээллийг ил болгох үйл ажиллагаанд сурталчилгаа хийх замаар нөлөөлөх боломжгүй. Мөн хувийн мэдээллийг ил болгосон явдалд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо бий болж чадахгүй.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6.	Захиргааны	Асуудал үүссэн гол	Зардал, үр өгөөж	Үр дүнгүй

	шийдвэр гаргах	шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	тооцох боломжгүй.	
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр боловсруулах, нийгмийн сүлжээ, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болгох улмаар хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, аюулгүй байдалд эрсдэл, хор хохирол үүсэж болзошгүй тул дээрх үйлдлийг хориглож, улмаар уг үйлдлийг хийсэн хувь хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хуулиар зохицуулснаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.	Зардал нэмэгдэхгүй боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй

Хүснэгт 6: Асуудал 3 - Хувь хүний мэдээлэл алдагдах эсвэл хулгайлагдах

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Хувь хүний мэдээлэл алдах эсвэл хулгайлагдах, цахим халдлагад өртөх замаар хувийн мэдээлэл алдагдсанаар нийгэмд гадуурхагдах, гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий нөхцөл байдал үргэлжилнэ.	Зардал нэмэгдэхгүй мөн үүссэн асуудал шийдэгдэхгүй	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүрэг	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй

	гүйцэтгүүлэх			
6.	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хувь хүний мэдээлэл алдах эсвэл хулгайлагдах, цахим халдлагад өртөх замаар хувийн мэдээлэл алдагдсанаар нийгэмд гадуурхагдах, гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх боломж бий болно.	Зардал нэмэгдэхгүй боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй

Хүснэгт 7: Асуудал 4 - Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ил болгох

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1. “Тэг” хувилбар	Хувийн мэдээлэл нь ил болсноор тухайн хүний ёс суртахууны гэм хорыг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн тохиолдол цөөн буюу бараг байхгүй. Иргэд энэ тохиолдолд хэнд хандахаа мэдэхгүй тул үүсэн шалтгаан шийдвэрлэгдэхгүй юм.	Зардал нэмэгдэхгүй мөн үүссэн асуудал шийдвэрлэгдэхгүй.	Үр дүнгүй
2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүн хангалттай бус
3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4. Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6. Захиргааны шийдвэр гаргах	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй

7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хувийн мэдээлэл нь ил болсноор тухайн хүнд ёс суртахууны гэм хор учрахаас сэргийлэх, тухайн хувь хүний зөвшөөрөлгүйгээр түүний хувь хүний болон эмзэг мэдээллийг ил болгосон этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэл бий болох ба ёс суртахууны гэм хоруыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрх үүсэх боломжтой.	Зардал нэмэгдэхгүй боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй
----	--------------------------------------	--	--	------------------

Хүснэгт 8: Асуудал 5 - Өөрийн хувь хүний мэдээлэлд хандах боломжгүй байдал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах, алдаатай мэдээллийг засах боломжгүй. Өөрийн мэдээллийн талаар төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудаас лавлагаа, мэдээлэл авах явдал хадгалагдсан хэвээр байна.	Зардал нэмэгдэхгүй мөн үүссэн асуудал шийдэгдэхгүй	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6.	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Мэдээлэл боловсруулагч төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд тухайн хувь хүний мэдээллийг эзэн өөрийн мэдээлэлд хандах	Зардал нэмэгдэхгүй боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй

		эрхийг олгож өгөх үүргийг хуулиар зааж өгснөөр цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах, алдаатай хувийн мэдээллийг засах боломж бий болно.		
--	--	--	--	--

Хүснэгт 9: Асуудал 6 – Хувь хүний эмзэг мэдээлэл зөвшөөрөлгүй боловсруулах, ашиглах

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	“Тэг” хувилбар	Хувийн эмзэг мэдээлэл болох үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, эрүүл мэнд, бэлгийн чиг хандлага болон бэлгийн амьдрал зэргийн мэдээллийг бусдад дамжуулах, ил болгосноор тухайн хүнийг гутаан доромжлох, дарамтлах, айлган сүрдүүлэх цаашлаад тухайн хүнийг амиа хорлоход хүргэх асуудал үргэлжилнэ.	Зардал нэмэгдэхгүй мөн үүссэн асуудал шийдэгдэхгүй	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Иргэдэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойлголт, мэдлэг өгөх ажлыг зохион байгуулж иргэдийг мэдлэгжүүлж болох хэдий ч хуулийн хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй хэвээр байна.	Зардал нэмэгдэнэ, үр дүн бага.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6.	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7.	Хууль тогтоомжийн	Хувийн эмзэг мэдээлэл болох үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг,	Зардал нэмэгдэхгүй	Үр дүнтэй

	төсөл боловсруулах	эрүүл мэнд, бэлгийн чиг хандлага болон бэлгийн амьдрал зэргийн мэдээллийг бусдад дамжуулах, ил болгосноор тухайн хүнийг гутаан доромжлох, дарамтлах, айлган сүрдүүлэхийг хуулиар хориглож, хуулийн дагуу хүлээлгэн хариуцлагын тогтолцоо бий болохоос гадна хохирсон тохиолдолд ёс суртахууны гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах боломжтой болно.	боловч эерэг үр дүнтэй.	
--	-----------------------	---	-------------------------	--

4.1. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбарууд нь дээрх асуудлыг шийдвэрлэх гарц биш болох нь тодорхой харагдаж байна.

Иймд дээр дэвшүүлсэн асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбараар зохицуулж, шийдвэрлэх нь хамгийн үр дүнтэй арга байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДЛАХ НЬ

4.1 ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг 1) Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө; 2) Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг энэ хэсгээр нарийвчлан судалсан болно.

- Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахаас урьдчилан сэргийлэх эерэг нөлөө үзүүлнэ.

- Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн орчин тодорхой болсноор мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудад мэдээллийн урсгалыг тодорхой зорилгоор, зохистойгоор ашиглах боломж үүснэ. Форбс сэтгүүлээс гаргасан Дэлхийн топ бизнесийн байгууллагын 2020 оны жагсаалтыг мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд тэргүүлж байгаагаас¹⁸ үзэхэд энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа Монгол Улсад хөгжих, дэлхийн хэмжээнийн байгууллагуудтай түншлэн ажиллах боломжийг бүрдүүлнэ. Улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад таатай нөхцөл бий болж, үндэсний эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Хүний эрхийн үндэсний комисст шинэ чиг үүрэг нэмэхтэй холбогдуулан нэмэлт зардал үүснэ.

- Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах ажиллагаанд баримтлах нэгдсэн стандарт бий болно.

Хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах талаар холбогдох байгууллагын ажилтнуудад сургалт явуулах шаардлагатай. Хувь хүний мэдээллийг хувь хүний зөвшөөрөлгүйгээр ашиглах, ил болгохтой холбоотой гэмт хэрэг буурна гэж үзэж байна.

- Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

(Хавсралт 3-аас Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, Нийгэмд үзүүлэх үр нөлөө, Байгаль орчинд үзүүлэх нөлөө тус бүрийн асуултуудад хэрхэн хариулсныг дэлгэрүүлэн харна уу)

¹⁸ <https://www.forbes.com/top-digital-companies/list/?fbclid=IwAR3FByv-RQXOxq94KXNnJTq9ftW89XlaBIaCmuJLzDgWvmDBrcWaRysyBRA#tab:rank>
https://www.forbes.com/just-companies/?fbclid=IwAR0xv1IN9km_k4mQ6DsI_FhKctboBld6SBR9Y2uFDMDDeNQ9UYSuHy2bjbMQ#21be7df62bf0

4.2 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, БУСАД ХУУЛЬТАЙ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурал 1995 онд Хувь хүний нууцын тухай хуулийг баталж, уг хуулиар хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж, хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болохоор тусгасан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж,

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17.1 дэх хэсэгт “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.” гэж, 17.2 дахь хэсэгт “Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.” гэж,

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 45/95 тоот тогтоолоор¹⁹ Компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийг зохицуулах удирдамжийг баталж, түүнд үндэсний хууль тогтоомжоор өгөгдөл хамгаалахтай холбоотой үндсэн зарчмуудыг дараах байдлаар нэгтгэн тогтоосон байдаг²⁰:

- Хууль ёсны болон шударга ёсны зарчим: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь шударга, хууль ёсны байх ёстой бөгөөд НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчимд харшлах ёсгүй.

- Үнэн зөв байх зарчим: өгөгдөл хянагчид өгөгдлийг үнэн зөв, хамааралтай байгаа эсэхийг шалгаж, хянах үүрэгтэй бөгөөд алдаа гаргахаас зайлсхийх ёстой.

- Тодорхой зорилгоор ашиглах зарчим: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь хууль ёсны байх ёстой бөгөөд хувийн өгөгдлийг зөвхөн тусгайлсан зорилгын дагуу цуглуулж, боловсруулах, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр өгөгдлийг бусад этгээдэд ашиглуулахгүй байх, өгөгдөл нь зөвхөн тухайн зорилгод шаардлагатай хугацаагаар хадгалагдах ёстой.

- Сонирхогч этгээд нэвтрэх боломжтой байх зарчим: өгөгдлийн эзэн тухайн өгөгдлийг хэрхэн ойлгомжтой хэлбэрээр цуглуулах, боловсруулах, нэвтрэхийг мэдэх эрхтэй байх ёстой.

¹⁹ Монгол Улс Хэвлэл мэдээллийн эрх зүй. Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх (Сургалтын гарын авлага), Глоб интернэшнл төв болон DW akademie, 2017 он

²⁰ <https://digitallibrary.un.org/record/85149?ln=en#record-files-collapse-header>

- Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эдгээр зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийг ялгаварлан гадуурхах аливаа онцгой тохиолдол гэж байх ёсгүй.

- Аюулгүй байдлын зарчим: зөвшөөрөгдөөгүй этгээд хандах, урвуулан ашиглах, гэнэтийн хүчин зүйлийн улмаас устах зэрэг байгалийн болон хүнээс хамаарах эрсдэлээс өгөгдлийг хамгаалах зохистой арга хэмжээ авах ёстой.

Монгол Улсын Их хурлаас 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр баталсан Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 7 дугаар зүйлд “Энэхүү конвенц нь Талуудын хувийн мэдээлэл, оршин байгаа газар, бусад мэдээллийг ил болгохыг шаардсан хууль тогтоомжийг хэрэглэх болон үүнтэй холбогдуулан буруу, таашаа, эсхүл бүрэн бус мэдээлэл өгсөн Талыг эрх зүйн үр дагавраас чөлөөлөх асуудлыг хөндөхгүй.”, мөн 14.1 дэх хэсэгт “Хувь хүн автоматжуулсан мэдээллийн системээр дамжуулан нөгөө Талд хүргүүлсэн цахим харилцаанд алдаатай мэдээлэл оруулсан бөгөөд тэрхүү автоматжуулсан мэдээллийн систем тухайн алдааг засах боломжийг түүнд олгоогүй бол тэр хувь хүн, эсхүл түүгээр төлөөлүүлсэн Тал алдаа гарсан цахим мэдээллийн хэсгийг хүчингүй болгох эрхтэй” гэж тус тус тусгасан.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

4.3. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААРХ НИЙГМИЙН ШААРДЛАГА

Хурдацтай хөгжиж буй мэдээллийн эрин үед төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах, мэдээллийг ашиглан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал нь нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага болж байна.

Хувь хүний мэдээллийг хамгаалах талаар иргэдээс авсан судалгааны үр дүнгээс харвал төрийн болон бусад үйлчилгээг авахад иргэдээс нэмэлт байдлаар хувийн мэдээллийг нь авдаг, хувь хүний хувийн мэдээллийг хууран мэхлэх, залилах зорилгоор ашиглах, тухайн хувь хүний мэдээллийг эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, хувь хүн, иргэн ямар нэг байдлаар өөрийн хувийн мэдээллийг алдсан тохиолдолд цаашид тухайн мэдээлэл нь буруу зорилгоор ашиглагдах эсвэл өөрийн нэр хүндэд сөргөөр нөлөөлнө гэсэн айдастай байдаг, иргэд цахим орчин дахь өөрийн хувийн мэдээлэлд бүрэн хяналт тавьж чаддаггүй, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад хадгалагдаж байгаа өөрийн хувийн мэдээллийн хамгаалагдсан байдалд итгэдэггүй, хувийн мэдээллээ устгуулж, засварлаж байгаагүй, иргэд өөрийн хувийн мэдээллээ бусдад алдсан тохиолдолд хэнд хаашаа хандахаа мэддэггүй зэрэг асуудлууд тулгардаг байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан иргэд хувийн мэдээллийг нь анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглахыг огт зөвшөөрөхгүй гэсэн бөгөөд хувийн мэдээллийг нь цуглуулах, боловсруулалт хийхээс өмнө өөрөөс нь заавал зөвшөөрөл авах шаардлагатай гэж үзсэн бол хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг заавал авах шаардлагатай гэжээ.

Судалгаанд хамрагдсан иргэд хувийн мэдээллийг хамгаалах чиг үүрэгтэй бие даасан төрийн байгууллага байх шаардлагатай ба хувийн мэдээллийг хамгаалах талаар тусгайлсан хууль батлах нь зүйтэй гэж үзсэн байна.

Харин хувь хүний мэдээллийг цуглуулж, хадгалдаг байгууллагын төлөөллөөс авсан судалгаанаас үзвэл судалгаанд хамрагдсан дийлэнх байгууллага хувь хүний мэдээллийг “эмзэг” ангилалд ялган хуваадаггүй бүх төрлийн хувийн мэдээллийг ижил төвшинд авч үздэг, хувь хүний мэдээллийг ашиглах зорилго, зорилтоо тодорхойлдоггүй, хувийн мэдээллийг хадгалах нөхцөл болон хугацааг тодорхойлж мөрддөггүй, хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр хил дамнуулан бусдад дамжуулдаг, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, хамгаалалт хариуцсан бүтэц эсвэл мэргэжилтэнгүй байна.

Цагдаа, Шүүхийн байгууллагаас авсан судалгаанаас харвал хувь хүний мэдээлэл алдагдах улмаар эд хөрөнгө, нэр хүнд, амь насанд хүртэл хохирол учрах тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа хэдий ч шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдэж байгаа хэргүүд нь нийт гэмт хэргийн тоотой харьцуулахад харьцангуй цөөн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар тусгайлсан хуулийн зүйл заалт байхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Өмнө дурдсны дагуу хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний мэдээлэл алдагдах, анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглагдах зэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлээгүй, хувийн мэдээллийг боловсруулах үйл

ажиллагаа түүний дотор хувийн мэдээлэл боловсруулахад хувь хүнээс зөвшөөрөл авах, хувь хүн болон тухайн хувийн мэдээллийг боловсруулагчийн эрх, үүрэг, тэдгээрийн хоорондын эрх зүйн харилцаа, хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулахад тавигдах шаардлага, хуулийн хориглолт, хязгаарлалтыг цогцоор нь зохицуулсан хууль байхгүй байгаа тул хувь хүний мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг шинээр боловсруулах хэрэгцээ шаардлагатай болохыг дээрх судалгааны үр дүн харуулж байна.

4.4. ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их хурал, Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагаас баталсан бодлогын баримт бичгүүдэд хувь хүний мэдээллийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог сайжруулах талаар дараах тодорхой зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

- 1.1. Монгол Улсын Их хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д *“Өгөгдөл хамгаалах тухай”* хуулийг боловсруулж батлуулах гэж;
- 1.2. Монгол Улсын Их хурлын 2018 оны 54 дүгээр тогтоол (Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай)-ын 2 дахь заалтад *“төрийн мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, өгөгдөл хамгаалах, цахим засгийг бэхжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой арга хэмжээг судалж танилцуулах”* гэж;
- 1.3. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Мэдээллийн аюулгүй байдал” Зорилт 7.5 дахь хэсэгт *“Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.”* гэж, мөн тус баримт бичгийн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Засаглалын бодлого” хэмээх Тавдугаар бүлгийн зорилгыг *цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих гэж тодорхойлсон бөгөөд тус баримт бичгийн Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) хэсгийн зорилтыг тодорхойлохдоо хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхээр, уг зорилтын хүрээнд 2021-2030 оныг мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх”* гэж,
- 1.4. Монгол Улсын Их Хурал 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсийг *“Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.”* гэж заасан. Мөн үзэл баримтлалын 3.6.2.3-т Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно, 3.6.3.1-д *“Мэдээлэл, түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задрахаас хамгаалагдсанаар нууцлал хангагдана”,* 3.6.3.7-д *“Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглоно.”* гэж;
- 1.5. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.2-т *“Хүний эрхийг дээдэлсэн, цахим*

засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж, 4.1.6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.” гэж,

- 1.6. Монгол Улсын Их хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.3.3-т “Иргэдэд захидал харилцаа, мэдээллээр үйлчилдэг цахилгаан болон шуудан холбоо, үүрэн телефон, интернэтийн үйлчилгээний байгууллагуудын иргэний хувийн болон захидал харилцааны нууцыг хамгаалах талаар стандарт тогтоож мөрдүүлэх, төрийн хяналтын систем тогтоох, эрх бүхий байгууллагын шийдвэрээр иргэний хувийн нууцтай танилцсан, чагнасан тохиолдол бүрийг бүртгэх журам, тогтолцоог бий болгоно”, 2.1.3.4 дахь хэсэгт “Иргэний хувийн болон захидал харилцаа, гэр бүл, эрүүл мэнд, эд хөрөнгийн нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ хохирогчид нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлнэ.” мөн 2.1.3.5 дахь хэсэгт “Хувь хүний нууцын тухай хуулийг тодорхой болгох, хувийн болон гэр бүлийн, захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, тэдгээрийг агуулсан зүйлсийн жагсаалтыг гаргах, хүний хувийн нууцтай холбоотой ажил үйлчилгээ эрхэлдэг бүх хэвшлийн байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулах, амлалт авхуулах зэргээр хариуцлагыг дээшлүүлнэ” гэж,
- 1.7. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлийн 5.4.4-т “Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж,
- 1.8. Засгийн газрын 2017 онд 47 дугаар тогтоолоороо баталсан “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” бодлогын баримт бичгийн 3.8.1-д “мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэх” гэж тус тус заасан.
- 1.9. Түүнчлэн Засгийн газар 2016 оны 4 дүгээр сарын 11-ний 204 дүгээр тогтоолоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталсан. Уг төлөвлөгөөний наймдугаар хэсэгт: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр зөвлөмжид тусгаснаас гадна хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа болон гол үүрэг хүлээх субъектүүдийг тодорхой зааж өгсөн байна.

Иймд энэхүү судалгааны үр дүнд хувь хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар эрх зүйн орчныг шинэ үүссэн нөхцөл байдал, техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн боловсронгуй болгох нийгмийн бодитой шаардлага бий болсон байх бөгөөд хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл хангалттай бүрдсэн гэж дүгнэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахад нийгэм даяар хувь хүний мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, боловсруулах, бусдын хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй эсвэл хуульд заасан үндэслэлгүйгээр ашиглах, боловсруулах, хувь хүний мэдээлэл бусдад алдагдах эсвэл хулгайлагдах, хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд ил болгох, тараах, өөрийн хувийн өгөгдөл, мэдээлэлд хандах тэдгээрийг засварлах боломжгүй байх, хувийн эмзэг мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглах, боловсруулах зэрэг асуудал нилээдгүй гарч байна. Эдгээр асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах боломжгүй байгаа тул энэ салбарт тусгайлсан хууль батлан гаргах замаар шийдвэрлэх боломжтой байна. Нөгөөтэйгүүр дээрх асуудлууд тодорхой зохицуулалтгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрхэд ноцтой заналхийлэл учруулж байгаа бөгөөд үүний тод жишээ нь нийгэмд үйлдэгдэж буй хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа үзүүлэлт юм.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлж, шийдвэрлэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн хувилбар буюу төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбаруудаас илүүтэйгээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй, оновчтой байгаа нь тодорхой байна.

Энэхүү тандан судалгаагаар хууль тогтоомж боловсруулах хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дэлгэрэнгүй судалсан болно.

Хүснэгт 10: Зохицуулалтын хувилбар

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: Шинээр хууль боловсруулах
Зорилгод хүрэх байдал	Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Мэдээллийн аюулгүй байдал” Зорилт 7.5 дахь хэсэгт “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж, “Алсын хараа-2050” баримт бичгийн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Засаглалын бодлого” хэмээх Тавдугаар бүлгийн зорилгыг цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих гэж тодорхойлсон бөгөөд тус баримт бичгийн Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) хэсгийн зорилтыг тодорхойлохдоо хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхээр, уг зорилтын хүрээнд 2021-2030 оныг мэдээллийн аюулгүй

	байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх” гэж тус тус заасан зорилгод хүрэхэд түлхэц болохуйц Хувь хүний мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин бүрдэнэ.
Хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасны дагуу хүний үндсэн эрх хангагдах эерэг нөлөө үзүүлнэ. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах хууль тогтоомжийн зохицуулалт тодорхой болсноор Форбс сэтгүүлээс гаргасан Дэлхийн топ бизнесийн байгууллагын 2020 оны жагсаалтыг мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд тэргүүлж байгаагаас ²¹ үзэхэд энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа Монгол Улсад хөгжих, дэлхийн хэмжээнийн байгууллагуудтай түншлэн ажиллах боломжийг бүрдүүлнэ. Улмаар энэ нь үндэсний эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Байгаль орчинд шууд нөлөөлөх нөлөөлөл байхгүй.
Зардал үр өгөөжийн харьцаа	Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийн төслийг баталж хэрэгжүүлсэнээр бага зардлаар өндөр үр дүнд хүрэх буюу зардал үр өгөөжийн харьцаа их байна.
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй.
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Олон улсын болон дотоодын хууль тогтоомжуудтай нийцэж байгаа болно.
Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Тухайн зохицуулалтаар иргэн, төр, аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, олон улсын байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө.

Ийнхүү зохицуулалтын хувилбар бүрийн үр нөлөөг харьцуулан судалсны үр дүнд хувь хүний мэдээллийг хамгаалах харилцаанд үүсэж буй асуудлуудыг тусгайлсан хууль батлах замаар шийдвэрлэх нь оновчтой байна.


²¹ <https://www.forbes.com/top-digital-companies/list/?fbclid=IwAR3FBYv-RQXOxq94KXNxJTq9ftW89XIaBIaCMuJLzDgWvmDBrcWaRysyBRA#tab:rank>

Түүнчлэн энэхүү асуудал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу гагцхүү хуулиар зохицуулж хамгаалах хүний салшгүй эрхэд хамаарах асуудал тул хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь оновчтой хувилбар болно.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Өнөөдрийн байдлаар НҮБ-ын Худалдаа болон хөгжлийн чуулгаас гаргасан судалгаагаар гишүүн 194 улсаас 132 улс Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийг баталсан байна. Ази Африкийн улсуудын 55 хувь нь Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталсан бөгөөд тэдгээрээс 23 нь хөгжиж байгаа улсууд юм. Дэлхийн улсуудын 66% нь мэдээлэл хамгаалах болон мэдээллийн аюулгүй байдлын талаар хуультай, 10% нь хуулийн төслөө боловсруулсан бөгөөд 19% нь хуульгүй бол 5%-ийн талаар мэдээлэл бүртгэгдээгүй байна гэжээ²².

Дэлхийн өгөгдөл хамгаалах болон өгөгдлийн аюулгүй байдлын хууль тогтоомжтой улсуудын индекс (2020 оны байдлаар)



Гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас үзэхэд Европын холбооноос баталсан 2016 оны Өгөгдөл хамгаалах ерөнхий хууль (GDPR) хамгийн өргөн хүрээний зохицуулалттай бөгөөд сайн жишиг хэмээн дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж байна. Өгөгдөл хамгаалах ерөнхий хуулийг Европын холбооны нийт гишүүн улсын хэмжээнд 2018 оноос эхлэн дагаж мөрдсөн бөгөөд энэ нь 11 бүлэг, 99 зүйлээс бүрдэнэ. Энэ хуулиар хувийн өгөгдлийг цуглуулах ашиглах зорилгын хүрээг тогтоож, цуглуулсан өгөгдлүүд болон өгөгдлийг боловсруулах, ашиглах зорилгын уялдаа, нийцлийг тодорхойлж, хувийн өгөгдлийг цуглуулж, ашиглахад баримтлах шударга, хууль ёсны, ил тод байх зэрэг зарчмыг тогтоож, хувийн өгөгдөлд тавигдах шалгуурыг тодорхойлсон.

Энэхүү хуулийн 5-р зүйлд хувийн мэлээллийг цуглуулах, хадгалах, ашиглахад баримтлах үндсэн зарчмуудыг тогтоосныг дурьдвал:

- Хуулийн дагуу, шударгаар, мэдээллийн эзэнд нээлттэй байдлаар өгөгдлийг боловсруулах;
- Хууль ёсны, нарийвчилсан, тодорхой илэрхийлсэн зорилгоор боловсруулах;
- Өгөгдөл нь боловсруулж буй зорилгод шууд хамааралтай, хүрээ хязгаартай байх;

²² <https://unctad.org/page/data-protection-and-privacy-legislation-worldwide>

- Хаана шаардлагатай байгаа, ямар хугацаанд хадгалах нь тодорхой байх;
- Өгөгдлийн эзний зөвшөөрлийг хувийн өгөгдлийг боловсруулах зорилгод шаардагдах хугацаанаас илүүгүй байхаар хадгалах;
- Хувийн өгөгдлийн аюулгүй байдлыг зохих ёсоор хангаж боловруулах.

Түүнчлэн хувийн өгөгдлийг хадгалах хугацааны хязгаарыг тогтоож, аюулгүй байдлыг хангах технологид тавигдах шаардлагыг тодорхойлсон.

Мөн хувийн өгөгдлийг боловсруулахад өгөгдлийн эзэн хяналт тавихаас гадна түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх зүйн байдлыг хуулиар тогтоосон байна. Энэхүү хяналт тавих төрийн байгууллага бие даасан хараат бус байх нь гол шалгуур байх бөгөөд хуульд тухайн байгууллагыг байгуулах, дарга, гишүүдийг сонгох, бүрэн эрх болон үйл ажиллагаа явуулах хугацааг тогтоох, гадны нөлөөгүй бие даан шийдвэр гаргах зэрэг асуудлыг тусгайлан зохицуулсан. Энэхүү хяналтын байгууллага иргэдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх бөгөөд цуглуулсан хууль бус эсвэл үнэн зөв биш мэдээллийг устгуулах эрх мэдэлтэй байдаг.

Европын холбооны гишүүн улсаар хязгаарлахгүйгээр Европын холбооноос баталсан Өгөгдөл хамгаалах ерөнхий хуулийг олон орон жишиг болгож дотоодын хувь хүний мэдээлэл, өгөгдөл хамгаалах хууль тогтоомжийг боловсруулсан байдаг.

Бид гадаад орнуудын хувь хүний мэдээлэл хамгаалах эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгаа хийхдээ НҮБ-ын Худалдаа болон хөгжлийн чуулгын мэдээллийн санд²³ бүртгэлтэй цахим худалдааны хууль тогтоомжууд буюу цахим гүйлгээ, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, өгөгдлийн хамгаалалт/аюулгүй байдал, кибер гэмт хэргийн хууль тогтоомж батлан хэрэгжүүлдэг улс орнуудаас сонгон авахаас гадна Dell EMC компанийн гаргадаг “Олон улсын хувь хүний мэдээлэл хамгаалах индекс²⁴”-т хамрагдсан хувь хүний мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хөгжлөөр дээгүүрт ордог улсуудаас сонгон авч хууль тогтоомжийг харьцуулав. Үүнд Англи, Герман, Япон, БНСУ, Швейцар, Сингапур, АНУ, Канад (4 муж), Финланд болон Эстони зэрэг 10 орны хувь хүний мэдээлэл хамгаалах болон хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийг судалж, харьцуулан авч үзсэн болно.

Энэхүү харьцуулсан судалгаанд:

- эрх зүйн зохицуулалт хийж буй хууль;
- хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийн зохицуулалтын ерөнхий агуулга;
- хувь хүний мэдээлэл хамгаалах тусгай зохицуулалт;
- хариуцлага.

гэсэн 4 үзүүлэлтээр авч үзлээ.

²³ <https://unctad.org/topic/ecommerce-and-digital-economy/ecommerce-law-reform/summary-adoption-e-commerce-legislation-worldwide>

²⁴ <https://www.delltechnologies.com/en-us/data-protection/gdpr/index.htm>

Хүснэгт 11. Гадаад орнуудын хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн харьцуулсан судалгаа

№	Улс орны нэр	Эрх зүйн зохицуулалт хийж буй хууль	Хуулийн зохицуулалтын ерөнхий агуулга	Хувь хүний мэдээлэл хамгаалах тусгай зохицуулалт	Хариуцлага
1.	БНСУ	Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2020-08-05); PIPA, 개인정보보호법/個人情報保護法) Эх сурвалж: https://www.privacy.go.kr/eng/laws_view.do?nttd=8186&imgNo=3 Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тушаал (2011-09-29); Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах журам (2011-09-29) Хувийн мэдээллийн хамгаалалт болон аюулгүй байдлын стандарт (2011-09-30)	Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь 10 бүлэг 76 зүйлээс бүрдэнэ. Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн зорилго нь хувийн мэдээллийг боловсруулж, хамгаалахдаа хувь хүний эрхэм чанарыг хүндэтгэж, хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад оршино.	Энэ хуулиар төрийн болон хувийн байгууллага хувь хүний мэдээллийг ашиглах, боловсруулах, устгахад баримтлах нийтлэг шалгуур, зарчмыг тогтоосон. Хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, дамжуулах, устгахад баримтлах иж бүрэн стандартыг тогтоосон. Мэдээллийн эзнээс бусад этгээд мэдээлэлд хандахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах асуудлыг зохицуулсан. CCTV гэх мэт дүрс мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг зөвхөн эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбайд суурьлуулж болохыг зөвшөөрсөн. Төрийн болон хувийн маргаан таслах чиг үүргийг Хувийн мэдээллийн маргааныг эвлэрүүлэн зуучлах хороо хариуцдаг.	Хууль зөрчсөн үйлдлийн шинж байдлаас хамааран хувь хүнд 10-с илүүгүй жилийн хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хорих эсвэл 100 сая хүртэлх воноор торгоно Хууль зөрчсөн үйл ажиллагааны шинж байдлаас хамааран 70 сая хүртэлх воноор торгоно (хамтарсан хариуцлага)

		Түүнчлэн хувийн мэдээллийг хамгаалах асуудлыг зарим нарийвчилсан хуулиар зохицуулж байна.			
2.	Сингапур	Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль 2012 Personal Data Protection Act Эх сурвалж: https://sso.agc.gov.sg/Act/PDPA2012	Энэ хууль 10 бүлэг, 68 зүйлээс бүрдэнэ. Энэ хуулийн зорилго нь аливаа байгууллага хувь хүний хувийн өгөгдлөө хамгаалах эрх болон тухайн байгууллагын үндэслэл бүхий зорилгоор хувийн мэдээллийг цуглуулж, ашиглаж, задруулах хэрэгцээний аль алиныг хүндэтгэх байдлаар хувийн өгөгдлийг цуглуулах, ашиглах болон задруулах ажиллагааг зохицуулахад оршино	Тодорхой төрлийн зорилгоор хувь хүний мэдээллийг ашиглахад мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахгүй байхаар зохицуулсан. Тухайн байгууллага мэдэгдсэнээр зөвшөөрөл авсанд тооцож гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор мэдээллийг бусад гэрээлэгчтэй хуваалцахыг зөвшөөрсөн байдаг.	Хувь хүний торгуулийн дээд хэмжээ 10,000 Сингапур доллар хүртэл байна. Хорих ял 3 жил хүртэл байна. Хариуцлага хүлээсэн боловч хууль зөрчсөн гэм буруутай үйлдлээ үргэлжлүүлсэн хэвээр байвал хоног тутамд эсвэл үргэлжлүүлсэн хугацаанд 1000 Сингапур долларын торгууль ногдуулна. Компанийн хувьд жилийн эргэлтийн хөрөнгө нь 10 сая Сингапур доллараас бага бол торгуулийн хэмжээ 1 сая Сингапур доллар, 10 сая Сингапур доллараас их бол торгуулийн хэмжээ жилийн эргэлтийн

					хөрөнгийн 10% хүртэл хэмжээтэй байна
3.	Япон	Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2003.05.30 Эх сурвалж: http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2781&vm=2&re=02	Энэ хууль 7 бүлэг, 88 зүйлтэй. Энэ хууль нь нийгмээрээ хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө үед хувийн мэдээлэлтэй ажиллах нийтийн хандлагыг тодорхойлох, энэ талаар баримтлах төрийн бодлогыг боловсруулах, хариуцлагыг тодорхой болгох, төв болон орон нутгийн байгууллагуудын үүргийг тогтоох, хувийн мэдээлэлтэй ажилладаг бизнесийн операторуудын дагаж мөрдөх журмыг тодорхой болгох, хувийн мэдээллийг хамгаалахад шаардлагатай бусад асуудлыг зохицуулах замаар Японы ард түмний амьдралын чанарыг бэхжүүлэх болон шинэ төрлийн үйлдвэрлэлийг бүтээн байгуулахад хувь нэмэр оруулж буй хувийн мэдээллийн урсгалыг зохих ёсоор ашиглах үйл ажиллагааны явцад хүний эрх, хувийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой.	Энэ хуулийн дагуу Хувийн мэдээллийг хамгаалах комис байгуулагдсан. Энэхүү байгууллага нь хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Хувийн мэдээллийг устгах, задруулах талаарх тохиолдлуудыг өргөн хүрээнд хуульчилсан. Эмзэг өгөгдлөөс бусад хувийн мэдээллийг мэдэгдэл өгөх замаар гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь зөвшөөрөл авсанд тооцогдоно. Мөн нэгэнт зөвшөөрөлтэй хүлээн авсан хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан. Хувийн мэдээлэл хамгаалах хувийн байгууллагыг магадлан итгэмжлэх асуудлыг зохицуулсан. Нууц нэрээр илэрхийлэгдсэн өгөгдөлтэй холбоотой харилцааг мөн зохицуулсан.	Хувь хүнд ногдуулах торгуулийн дээд хэмжээ 1,000,000 иен хүртэл байна. Эсвэл 1 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хорих ял онооно. Байгууллад оногдуулах торгуулийн дээд хэмжээ 100 сая иен байна.
4.	Герман	DSGVO (<i>Datenschutz-Grundverordnung</i>) буюу Өгөгдөл	Энэ хууль 11 бүлэг, 99 зүйл, 173 хэсэгтэй. Хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах явцад	Герман улсад 17 өөр өгөгдөл хамгаалах байгууллагууд байдаг бөгөөд тэдгээрийн нэг нь холбооны, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ	Жилийн эргэлтийн хөрөнгийн 2 хувь хүртэл эсвэл 10,000,000 евро хүртэл торгууль

	хамгаалах ерөнхий зохицуулалтын тухай хууль (GDPR) 2018.05.28 Эх сурвалж: https://www.privacy-regulation.eu/en/index.htm	хэрхэн хамгаалахыг Европын Холбооны хүрээнд бэхжүүлэх, уялдуулах зорилготой. Мэдээлэл эзэмшигчийн эрх ба Хувийн мэдээллийг гуравдагч улс эсвэл олон улсын байгууллагад шилжүүлэх талаар зохицуулсан. Хараат бус хяналтын байгууллагууд болон Хамтын ажиллагааг зохицуулсан. Байгууллагууд хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах бүх үйл явцад хувийн нууцыг хамгаалах орчин үеийн технологи, бодлогыг хэрэгжүүлэхээр заасан. Байгууллагуудаас бизнесийн нарийн тодорхойлогдсон зорилгын хүрээнд өгөгдөл цуглуулахыг хамгийн бага хэмжээнд хязгаарлахыг шаарддаг. Байгууллагаас хувь хүмүүсийн талаар ямар өгөгдөл, хэрхэн, яагаад цуглуулж байгаа талаар нээлттэй ил тод байхыг шаарддаг. Мэдээллийн хянагч нь 72 цагийн дотор хувь хүний эрхэд аюул учруулж болзошгүй өгөгдлийн зөрчлийг холбогдох Мэдээлэл Хамгаалах Газар болон зарим тохиолдолд нөлөөлөлд өртсөн мэдээллийн эздэд мэдэгдэх	эрхэлдэг компаниудыг харьяалдаг бол бусад 16 нь Германы мужуудад хадгалагддаг бөгөөд өөрсдийн харьяаллын дагуу бизнес эрхэлдэг хувийн компаниудад хяналт тавих эрх мэдэл бүхий байдаг. И-маркетинг, онлайн нууцлалын талаар тусгасан.	ногдуулна. (83.4 EU GDPR)
--	---	---	---	----------------------------------

			үүрэгтэй.		
5.	Англи	Data protection act 2018 буюу Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалтын тухай хууль (GDPR) 2018 Эх сурвалж: https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/contents/enacted	Энэ хууль 7 хэсэг, 15 бүлэг, 215 зүйлтэй. Энэ хууль нь Европын Холбооны улсуудын өгөгдлийг хамгаалах тухай сүүлийн үеийн хууль тогтоомжийн дагуу хувийн өгөгдлийг хамгаалах шинэ стандартыг тогтоож, тэдний өгөгдлийн ашиглалтад илүү хяналтыг тавихыг зорилго болгосон. Энэхүү хуульд заасан дөрвөн үндсэн харилцаа бол ерөнхий мэдээлэл боловсруулах, хууль сахиулах байгууллагын мэдээлэл боловсруулах, тагнуулын албанаас мэдээлэл боловсруулах, зохицуулалтын хяналт, хэрэгжилт болно. Хувийн мэдээллийг ашиглах үүрэгтэй хүн бүр “өгөгдөл хамгаалах зарчим” хэмээх хатуу дүрмийг баримтлах ёстой. Үүнд, шударга, хууль ёсны, ил тод тодорхой зорилгоор ашигласан, хамааралтай, зөвхөн шаардлагатай зүйлээр хязгаарлагдмал байдлаар ашигладаг, зөвшөөрөлгүй боловсруулах, нэвтрэх, алдах,	Замын хөдөлгөөний мэдээлэл, Күүки мэдээллийг хэрхэн боловсруулах талаар тусгасан. GDPR нь Их Британид хүүхдийг Хувийн мэдээллийг боловсруулахыг зөвшөөрч болох насны доод хязгаарыг 13-16 насны аль ч насныханд тохируулах боломжийг олгодог. Илүү эмзэг мэдээллийн хувьд хууль эрх зүйн хамгаалалт илүү хүчтэй тусдаг: үндэс угсаат, улс төрийн үзэл бодол, шашин итгэл үнэмшил, генетик биометрик (танихад ашигладаг газар) эрүүл мэнд бэлгийн амьдрал эсвэл чиг баримжаа, Эрүүгийн ял шийтгэл, зөрчлийн талаарх хувийн мэдээллийн тусдаа хамгаалалт байдаг.	20 сая евро эсвэл жилийн эргэлтийн хөрөнгийн 4 хувь хүртэл

			устгах, гэмтээхээс хамгаалах зэрэг зохих аюулгүй байдлыг хангасан байдлаар зохицуулсан.		
6.	Финланд	Data protection act 2018 буюу (GDPR)-д үндэслэн Өгөгдөл хамгаалах тухай шинэ хууль баталсан 2018 Эх сурвалж: https://www.finlex.fi/en/aki/kaannokset/2018/en/20181050.pdf	Энэ хууль 6 бүлэг, 38 зүйлтэй. Мэдээлэл хамгаалах омбудсман нь үндэсний мэдээллийн хамгаалалтын байгууллага хэвээр байгаа бөгөөд Финландын бүх өгөгдлийг хамгаалах чиглэлээр хяналт тавьдаг. Мөн төрийн эрх баригчид "нийтийн ашиг сонирхол" нэрээр иргэдийн хувийн мэдээлэлд нэвтрэх эрх мэдлийг нэмэгдүүлсэн. Төрийн байгууллагуудад "нийтийн ашиг сонирхол" -той холбоотой асуудлаар иргэдийн мэдээллийг авах чадварыг нэмэгдүүлж, зарим байгууллагуудад Европын Холбооны Мэдээлэл хамгаалах ерөнхий журмын дагуу торгууль ногдуулахгүй байх эрхийг олгосон.	Байршил болон күүки өгөгдлийн талаар зохицуулсан. Финландад хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой илүү нарийвчилсан хууль тогтоомж байдаг. (2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Ажил, амьдралын нууцлалыг хамгаалах тухай хууль (759/2004)) - өргөдөл гаргагчид болон ажилчтны хувийн мэдээллийг боловсруулах, ажилтнуудад хяналт тавих, ажилтны хувийн нууцтай холбоотой бусад асуудлаар харьцангуй хатуу дүрмийг тогтоодог.	Эрүүгийн хуулиар зохицуулагдана. Мөн Өгөгдөл хамгаалах Омбудсмен нөхцөлт торгуулийг ногдуулж болдог. Өгөгдөл хамгаалах Омбудсмен болон түүний орлогч торгууль ногдуулах эрхтэй.
7.	Швейцар	Мэдээлэл хамгаалах тухай холбооны хууль (1992)-ийг 2018 онд GDPR-тай уялдуулан шинэчилсэн (Federal Act on Data	8 хэсэг, 39 бүлэгтэй Швейцар болон гадаадад байгаа хянагч, боловсруулагчид, тухайлбал: -нууцлалын бодлого, мэдэгдлийг өргөтгөсөн мэдээллийн үүрэгтэй	Күүки ашиглах талаар тусгасан	10,000 хүртэл хэмжээтэй Швейцар франкын торгууль

		protection) Эх сурвалж: https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19920153/index.html	нийцэж байгаа эсэхийг хянах; -хувь хүний эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хүсэлтийг шийдвэрлэх, өгөгдлийн зөрчлийг арилгах (цаг алдалгүй мэдэгдэх) үйл явцыг бий болгох; -мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, шинэчлэх; Хянагч ба боловсруулагчид өгөгдөл боловсруулах үйл ажиллагааны бүртгэлийг холбогдох хариуцлагын дагуу хөтлөх ёстой.		
8.	Эстони улс	Эстони улсын Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль (2019-01-15) Эх сурвалж: https://www.riigiteataja.ee/en/eli/523012019001/consolide-Эстони	Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль нь 7 бүлэг, 76 зүйлтэй. Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хариуцлагыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагын хувийн өгөгдөл тэдгээрийг боловсруулах тодорхой үндэслэлийг тусгасан төрийн болон захиргааны хяналтыг зохицуулна.	Хүүхдийн хувийн өгөгдлийг боловсруулах: Нийгмийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хүүхдийн хувийн өгөгдлийг боловсруулах тохиолдолд Эстони улс ийм төрлийн боловсруулалтыг зөвхөн 13 насанд хүрсэн хүүхдэд л хийж болно. Хэрэв хүүхэд 13 насанд хүрээгүй бол тухайн хүүхдийн хууль ёсны төлөөлөгч (ихэнх тохиолдолд эцэг, эх) зөвшөөрсөн тохиолдолд хувийн өгөгдлийг боловсруулахыг зөвшөөрдөг байна. Мөн Сэтгүүл зүйн зорилгоор	Эстони улсын өгөгдөл хамгаалах хяналтын албаны зааврыг дагаж мөрдөөгүй тохиолдолд Шийдвэр гүйцэтгэх болон Торгуулийн төлбөрийн тухай хуулинд заасан журмын дагуу торгуулийн арга хэмжээ авах ба торгуулийн дээд хэмжээ нь 20,000,000 евро хүртэл байна.

				хувийн өгөгдлийг боловсруулж, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулж болно. Энэ нь зөвхөн нийтийн ашиг сонирхол, түүнчлэн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд нийцсэн бол мэдээлж болно. Хувийн өгөгдлийг задруулах нь аливаа мэдээллийн эзний эрхэд үлэмж их хохирол учруулах ёсгүй. Эрдэм шинжилгээний, уран сайхны болон уран зохиолын илэрхийлэлд зориулж хувийн өгөгдлийг өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж болно. Энэ нь эзний эрхэд үлэмж их хохирол учруулахгүй бол задруулж болно. Олон нийтийн газар хувийн өгөгдлийг боловсруулах: Ирээдүйд задруулахад зориулагдсан аудио болон дүрс бичлэгийг олон нийтийн газар хийхдээ өгөгдлийн эзний зөвшөөрлөөр тухайн аудио бичлэг хийсэн бол мэдэгдэх үүрэгтэй. Мэдэгдлийн үүрэг нь олон нийтийн арга хэмжээнд	
--	--	--	--	---	--

				хамаарахгүй.	
9.	АНУ	Нууцлалын тухай хууль 1974 <i>/Privacy Act of 1974/</i> Эх сурвалж: https://www.justice.gov/opcl/overview-privacy-act-1974-2020-edition (October 16, 2020 Pre-Publication Draft)	1973 онд Эрүүл мэнд, боловсрол, халамжийн газраас (HEW²⁵) бүртгэл, компьютер, иргэдийн эрх гэсэн тайлан гаргаснаар дараах зөвлөмжүүдийг хуульд багтаасан байдаг нь автоматжуулсан мэдээллийн баазыг хувь хүмүүст хариуцуулдаг байгууллагуудаас дараах зүйлийг хийхийг шаардсан: (1) энэхүү өгөгдлийг хамгаалах хамгаалалт гаргах, (2) жил бүр ямар мэдээллийн сан хадгалж, ямар төрлийн мэдээлэл хадгалж байгааг олон нийтэд тайлагнах мөн хувь хүний "өгөгдлийн субъект-ууд" -д байх ёстой эрхийн жагсаалтыг багтаасан байна. Компьютержсон мэдээллийн бааз үүсгэж ашиглаж байгаа нь хувь хүний нууцлалын эрхэнд хэрхэн нөлөөлж буйтай холбогдуулан дараах дөрвөн хувийн мэдээлэлд процедурын болон материаллаг эрхийг бий болгох замаар нууцлалыг хамгаалах хуулийн зохицуулалтыг гаргажээ: 1. Төрийн байгууллагуудыг хувь хүний хадгалагдсан аливаа бүртгэлийг тухайн	Нууцлалын тухай хуулийн (b) дэд хэсэгт засгийн газрын байгууллага бүртгэлийн системд авагдсан мэдээллийг задруулахыг хязгаарласан. Агентлаг тухайн хүнээс зөвшөөрөл авсан эсвэл хуульд заасан арван хоёр нөхцлийн аль нэгийг хангаж чадах тохиолдолд ийм мэдээллийг ил болгохыг зөвшөөрсөн байдаг. Мөн Агентлаг нь Нууцлалын тухай хуулийн дагуу хэн мэдээлэл хүссэн талаар бүртгэл хөтлөх ёстой. Хууль сахиулах байгууллага нь мэдээллийн сангийнхаа хэвийн байдал, шинж чанарыг Холбооны бүртгэлд нийтэлж, тогтмол хэрэглээ, өгөгдөл хадгалах бодлого, систем хариуцсан албан тушаалтны холбоо барих мэдээллийг оруулна. Шүүхийн шийдвэр эсвэл зарлан дуудах хуудаснаас болж бүртгэлээ ил болгосон тохиолдолд хувь хүнд	Нууцлалын тухай хууль дахь заалтыг зөрчсөн тохиолдолд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Иргэний: Хэрэв агентлаг (1)(d) дэд хэсэгт заасны дагуу хувь хүн өөрийн бүртгэлд нэвтрэхийг зөвшөөрөхөөс татгалзвал тухайн иргэн иргэний шүүхэд нэхэмжлэл гаргаж, бүртгэлийг хийлгэх боломжтой. Шүүх нь АНУ-ын өмгөөлөгчийн төлбөрийг зохих ёсоор төлж болно. Хэрэв агентлаг Нууцлалын тухай хуулийн хэсгийг зөрчсөн бөгөөд шүүх энэхүү зөрчлийг "санаатай буюу санаатайгаар"

²⁵ <https://www.epic.org/privacy/hew1973report/>

			хүнд үзүүлэхийг шаарддаг. 2. Тэрхүү тусгай байгууллагууд нь “Мэдээллийн шударга практик” буюу тодорхой захирамж зөвлөмжийг хувийн мэдээллийг цуглуулах болон боловсруулахдаа дагаж мөрдөх шаардлагатай 3. Агентлагууд тухайн хүний мэдээллийг бусад хүмүүс болон агентлагуудтай хэрхэн хуваалцах талаар хязгаарлалт тавигддаг 4. хууль зөрчсөн тохиолдолд хувь хүмүүс нь Засгийн газрыг шүүхэд өгөх боломжтой. Гүйцэтгэх хэлтэс, цэргийн алба, бие даасан зохицуулах агентлагууд, засгийн газрын хяналттай корпорацууд бүгд энэ хуульд хамрагдана. Энэ хуулийн 7-р (хязгаарлалт тавигддаг) хэсгээс гадна муж, орон нутгийн засаг захиргаа Нууцлалын тухай хуульд хамрагдаагүй боловч муж улсууд хувь хүний бүртгэл хөтлөх тухай хуультай байж болно. Эх сурвалж:	мэдэгдэх ёстой; мөн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах зохих журам, хамгаалалтыг бий болгох ёстой байдаг.	үйлдсэн гэж үзвэл шүүх АНУ-д зөрчлийн улмаас учирсан бодит хохирлыг тухайн хүнд төлөх ёстой. Гэхдээ ямар ч тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх эрх бүхий хүн 1,000 ам.доллараас багагүй нөхөн төлбөр авна. Эрүүгийн: 5000 хүртэл ам.долларын торгууль ногдуулж болно. Эх сурвалж: https://www.justice.gov/opcl/overview-privacy-act-1974-2020-edition/remedies
--	--	--	--	---	---

			https://epic.org/privacy/1974act/ https://www.justice.gov/opcl/overview-privacy-act-1974-2020-edition		
10.	Канад улс	Хувийн мэдээлэл хамгаалах болон цахим баримт бичгийн тухай хууль (2000-04-13) Эх сурвалж: https://laws-lois.justice.gc.ca/ENG/ACTS/P-8.6/index.html	Хувийн мэдээлэл хамгаалах болон цахим баримт бичгийн тухай хууль нь 7 бүлэг 72 зүйлтэй. Тус хуулийн зорилго нь хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, задруулах тэдгээрийн хувийн мэдээллийн талаарх хувийн нууцыг хадгалах эрх, тодорхой зорилгод нийцсэн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулах байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх харилцааг зохицуулахад оршино.	Тодорхой нөхцөлд цуглуулсан, ашигласан эсхүл задруулсан хувийн мэдээллийг хамгаалах, мөн мэдээлэл, гүйлгээг дамжуулах, бүртгэхэд харилцаа холбооны цахим хэрэгслийг ашиглахад Канадын нотлох баримтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар цахим худалдааг дэмжих, сурталчлахад энэ хууль үйлчилнэ. Хувь хүнийг тодорхойлж болохуйц аливаа бүртгэгдсэн хувийн мэдээллийг нууцад тооцож хамгаална: Үүнд: 1. арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, нас, гэр бүлийн байдал; 2. хувь хүний боловсрол, эрүүл мэнд, эрүүгийн хариуцлага болон хөдөлмөр эрхлэлтийн түүх, санхүүгийн	Байгууллага нь өөрийн мэдээллийн санд байдаг хувь хүний мэдээлэлтэй холбоотой аюулгүй байдлын хамгаалалтыг ноцтой зөрчсөн энэ нь хохирол учруулах бодит эрсдэлийг бий болгож байгаа нь үндэслэлтэй гэж үзвэл энэ талаар Төлөөлөгчид мэдэгдэж шийдвэрлүүлнэ

				гүйлгээний талаарх мэдээлэл; 3. аливаа олгогдсон дугаар эсвэл тэмдэг; 4. хаяг, хурууны хээ эсхүл цусны бүлэг; 5. үзэл бодол эсхүл бусдын тухай үзэх үзэл бодол, тусламж, шагнал, урамшуулал; 6. төрийн байгууллагад илгээсэн хувийн болон нууц захидал.	
	Канадын Альберта муж	Альберта мужийн Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (2004-01-01) Эх сурвалж: https://www.qp.alberta.ca/documents/Acts/P06P5.pdf	Альберта мужийн Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь 7 бүлэг 75 зүйлтэй. Энэхүү хуулийн зорилго нь байгууллагаас хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, задруулах үйл ажиллагааг хувь хүний хувийн мэдээллийг хамгаалах эрхийг хамтад нь хүлээн зөвшөөрөх, мөн хувийн мэдээллийг зорилгын хүрээнд цуглуулах, ашиглах эсхүл задруулах байгууллагын хэрэгцээ шаардлагыг зохицуулахад оршино.	Альберта мужийн Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд: Хувийн мэдээллийг задруулахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах ба эдгээр зөвшөөрөл нь ямар зорилгоор хувь хүний мэдээллийг задруулж байгаа талаар байх ба тус зөвшөөрөл нь амаар, бичгээр болон цахим харилцааны хэлбэрээр байхыг зөвшөөрсөн байна. Байгууллагууд хувийн мэдээллийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа боловсруулах ёстой. Эдгээр бодлогыг байгууллагаас хүсвэл бичгээр гаргаж, хувь хүмүүст өгөх боломжтой. Тэд тухайн байгууллага дахь	Төлөөлөгч хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах эсхүл задруулахтай холбоотой зөрчил, хувийн мэдээллийг олж авах эсхүл хандалт хийхтэй холбоотой зөрчил гаргаж гэмт хэрэг үйлдсэн хүнд 10,000 Канад доллар, хуулийн этгээдэд 100,000 хүртэлх Канад долларын торгуул ногдуулна.

				мэдээллийг хэрхэн зохицуулж, хамгаалах талаар зохицуулсан байх ёстой. Жишээлбэл: 1. дохиолол зэрэг 2. технологийн аюулгүй байдал, тухайлбал нууц үгийн хамгаалалт, компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж дээр шифрлэлт хийх нууцлалын гэрээ, мэдээлэл технологийг ашиглах нөхцөл зэрэг захиргааны аюулгүй байдал зэрэг байна.	
	Канадын Квебек муж	Квебек мужийн хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль (1994-01-01) Эх сурвалж: http://legisquebec.gouv.qc.ca/en/showdoc/cs/P-39.1	Квебек мужийн хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль нь 10 бүлэг 117 зүйлтэй. Тус хууль нь Иргэний хуулийн 35-40 дүгээр зүйлд заасан хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой эрх, Иргэний хуулийн 1525 дугаар зүйлд заасан хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах явцад хувь хүний мэдээлэл цуглуулах, хадгалах, ашиглах эсхүл гуравдагч этгээдэд дамжуулах бусад этгээдэд дамжуулахад хувь хүний хувийн мэдээлэлтэй холбоотой тодорхой дүрэм боловсруулах харилцааг зохицуулна.	<i>Гуравдагч этгээдэд хувийн мэдээллийг дараах тохиолдолд дамжуулна. Үүнд:</i> Хувийн мэдээллийг хадгалж байгаа хуулийн этгээд нь хувь хүний мэдээллийг эзний зөвшөөрөлгүйгээр хүн болон байгууллагад дамжуулж болно. 1. Өмгөөлөгч; 2. Квебек мужийн хуулийн дагуу гэмт хэрэгт холбогдсон хүний мэдээлэл шаардлагатай бол Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх газрын даргад; 3. Шүүхэд; 4. Тухайн хувь хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж буй нөхцөл байдалтай холбоотой нэн яаралтай нөхцөл байдлын	Хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, гуравдагч этгээдтэй харилцах эсхүл хувийн мэдээлэл ашиглахтай холбоотой зөрчилд 1000-10000 Канад долларын торгууль ногдуулах ба давтан гэмт хэрэг хэрэг үйлдсэн тохиолдолд 10,000-аас 20,000 Канад долларын торгууль ногдуулна.

				үед мэдээллийг заавал дамжуулах; 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэхдээ холбоотойгоор хувийн мэдээлэл дамжуулах.	
Канадын Бритиш Колумб муж	Бритиш Колумб мужийн Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2004-01-01) Эх сурвалж: https://www.bclaws.ca/civ/document/id/complete/statreg/03063_01	Бритиш Колумб мужийн Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь 12 бүлэг 60 зүйлтэй. Энэхүү хуулийн зорилго нь хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагуудад олгохын зэрэгцээ хувь хүмүүст өөрсдийн хувийн мэдээлэлд нэвтрэх хүсэлт гаргах эрхийг зөвшөөрөх харилцааг зохицуулахад оршино. Хувийн хэвшлийн байгууллагад дараах байгууллагууд хамаарна. Үүнд: - Корпораци; - Мэргэжлийн холбоод; - Худалдааны холбоо; - Нөхөрлөл, түншлэл; - Хувийн сургууль, коллеж; - Арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аливаа хувь хүн.	Бритиш Колумб мужийн Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиар байгууллагууд хувь хүний мэдээллийг хамгаалахдаа биет, захиргааны болон техникийн хамгаалалт хийх ёстой. Үүнээс техникийн хамгаалалтыг нарийвчлан авч үзвэл 1. Компьютерын мониторуудад хувийн мэдээллийг байрлуулсан тохиолдолд тухайн Компьютерын төхөөрөмжид ажилтан эсвэл зочин зөвшөөрөлгүйгээр харах боломжгүй болгоно; 2. Нууц үгээр хамгаалагдсан компьютерын дэлгэцийг ашиглах; 3. Компьютерын сүлжээгээ ашиглан халдлагад өртөхөөс хамгаалах (халдлага илрүүлэх программ, вирусийн эсрэг программ, шифрлэлт); 4. Зөвхөн найдвартай	Хууль зөрчиж хувийн мэдээллийг цуглуулах, хууран мэхлэх, албадах, Төлөөлөгчөөс гаргасан тушаалыг биелүүлэхгүй байх зэрэг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Эдгээр зөрчилд хүнийг 10 000 ам.доллар хүртэлх, хуулийн этгээдэд 100,000 ам.доллар хүртэлх хэмжээний торгуулийн арга хэмжээ авна.	

				гэдгийг бататгахын тулд хүчтэй, аюулгүй нууц үг ашиглан ажилтнууд компьютерын сүлжээнд нэвтрэх орох зэрэг байна.	
--	--	--	--	--	--

Харьцуулсан судалгааны дүнд орнуудын хууль тогтоомжийн онцлог зохицуулалтаас дурдвал:

БНСУ-н Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжоор хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, дамжуулах, устгахад баримтлах иж бүрэн стандартыг тогтоосон. CCTV гэх мэт дүрсэн мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг зөвхөн эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбайд байрлуулж болохыг зөвшөөрсөн.

Сингапурын Хувийн өгөгдөл хамгаалах тухай хуулийн зохицуулалт бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлийг баримталдаг бөгөөд тус хуулийн онцлогоос дурьдвал тухайн байгууллага мэдэгдсэнээр зөвшөөрөл авсанд тооцож гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор мэдээллийг бусад гэрээлэгчдэд дамжуулахыг зөвшөөрсөн байдаг.

Япон Улсын Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бие даасан байгууллагын эрх хэмжээг тодорхойлсон байна. Эмзэг өгөгдлөөс бусад хувийн мэдээллийг мэдэгдэл өгөх замаар гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь зөвшөөрөл авсанд тооцогдоно. Мөн нэгэнт зөвшөөрөлтэй хүлээн авсан хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Европын холбооны улсуудын хувьд Өгөгдөл хамгаалах ерөнхий хууль (GDPR)-ийг баталж мөрдүүлдэг бөгөөд тус хуулийн онцлог зохицуулалтыг өмнө дэлгэрэнгүй дурьдсан тул энэ тайлангийн 66-67 дахь талаас үзнэ үү.

Эстони улсын Хүүхдийн хувийн өгөгдлийг боловсруулах хуульд сэтгүүл зүйн зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулж, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулж болохоор зохицуулсан байдаг. Энэ нь зөвхөн нийтийн ашиг сонирхол, түүнчлэн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд нийцсэн бол зөвшөөрөгдөнө. Хувийн өгөгдлийг задруулах нь мэдээллийн эзэнд үлэмж их хохирол учруулах ёсгүй. Эрдэм шинжилгээ, уран сайхны болон уран зохиолын илэрхийлэлд зориулж хувийн өгөгдлийг өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж болно. Энэ нь өгөгдөл эзэмшигчид үлэмж их хохирол учруулахгүй бол зөвшөөрөгдөнө. Мөн дээрх хуульд олон нийтийн газар хувийн өгөгдлийг боловсруулах талаар зохицуулалт тусгагдсан байх бөгөөд ирээдүйд задруулахад зориулагдсан аудио болон дүрс бичлэгийг олон нийтийн газар хийхдээ өгөгдлийн эзний зөвшөөрлөөр тухайн аудио бичлэг хийсэн бол мэдэгдэх үүрэгтэй. Мэдэгдлийн үүрэг нь олон нийтийн арга хэмжээнд хамаарахгүй байхаар заажээ.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байгаа дээрх орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлогоос үзэхэд гадаад улсууд хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, нууцтай холбоотой бие даасан хуультай хэдий ч хувь хүний мэдээлэл хамгаалах тусгайлсан хууль баталж, хуулиар хамгаалагдах хувь хүний мэдээллийн цар хүрээг тогтоож, мэдээллийн урсгалд хяналт тавих, хамгаалах механизмыг бүрдүүлжээ. Мөн мэдээллийн эзэн, мэдээлэл дамжуулагч, боловсруулагч, ашиглагч нарын эдлэх эрх, хүлээх үүргийг нарийвчлан тодорхойлжээ. Хувь хүний мэдээллийг зөв зохистойгоор ашиглах, боловсруулах, дамжуулах ажиллагааг өргөн хүрээнд зохицуулсан байгаа нь хүний эрхийг хамгаалаад зогсохгүй мэдээлэл, технологийн үсрэнгүй хөгжлийн хурдад нийцүүлж энэ төрлийн үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг дэмжиж, цаашилбал улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх дүр зургийг харуулж байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Бид Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу үндсэн 7 үе шаттайгаар Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны дүнд хувь хүний мэдээллийг хамгаалахтай харилцааг тусгайлсан хууль батлах замаар шийдвэрлэх нь оновчтой болохыг тогтоосон бөгөөд Хувь хүний мэдээллийг хамгаалах хуулийн төслийг боловсруулахдаа анхаарвал зохих зүйлсийг дараах байдлаар зөвлөж байна. Үүнд:

1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/95 тоот Шийдвэрээр баталсан “Компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийг зохицуулах удирдамж”-д заасан үндэсний хууль тогтоомжид харгалзан үзвэл зохих хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах 10 зарчмыг харгалзан үзэж хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалахад баримтлах зарчмуудыг харгалзан үзэх;
2. Хувь хүний мэдээллийг эрсдлийн түвшингээр ангилж хувь хүний эмзэг мэдээлэл, генетикийн мэдээлэл, биометрик мэдээлэл, эрүүл мэндийн мэдээллийг ялгамжтай тодорхойлж тэдгээрийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулахад баримтлах онцлог зохицуулалтыг тусгах;
3. Мэдээлэл эзэмшигчийн эрх зүйн байдлыг тодорхойлж мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах үйл ажиллагаанд түүний оролцоог (зөвшөөрөл өгөх болон мэдэгдэл хүлээн авах) тодорхой хуульчлах;
4. Хувь хүний мэдээллийг хариуцаж, цуглуулж, боловсруулж, дамжуулж, ашиглаж буй этгээдийн эрх, үүргийг нарийвчлан тогтоох;
5. Хувь хүний мэдээлэл хамгаалах эрх бүхий бие даасан байгууллагын эрх зүйн байдлыг тогтоох;
6. Хувь хүний мэдээллийг эрдэм шинжилгээ, судалгаа, статистикийн зорилгоор ашиглах шаардлага байгааг харгалзан үзэж үүний зааг ялгааг гаргаж хуульчлах;
7. Хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн систем, төхөөрөмжид хувь хүний мэдээллийг цуглуулах, хадгалах, түүнийг боловсруулах, ашиглах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох;
8. Хуульд дэлхийн хагжлийн чиг хандлага, нэгэнт туршигдсан сайн жишиг тухайлбал Европын холбооноос 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Хувь хүний өгөгдөл хамгаалах ерөнхий хууль 2016/679 (GDPR)-ийн агуулга, зарчмыг харгалзан үзэж олон улсын бизнесийн үйл ажиллагаан дахь хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний мэдээллийг хилийн чанадад дамжуулахтай холбоотой зохицуулалтыг тусгах;
9. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-иудад хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын эсрэг зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг тусгах шаардлагатай байна.

ХАВСРАЛТ 1

ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТАЛААР ЗОХИЦУУЛАЛТ АГУУЛСАН ХУУЛИЙН ТҮҮВЭР

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хуулиудад хувь хүний нууцын талаар зохицуулалт тусгагдсан байна.

№	Хуулийн нэр	Хуулийн заалт
1.	Монгол улсын үндсэн хууль	Арван зургаадугаар зүйл. 17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.</u>
2.	Хувь хүний нууцын тухай хууль	2 дугаар зүйл.Хувь хүний нууцын тухай ойлголт "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ. 4 дүгээр зүйл.Хувь хүний нууцын төрөл 1.Хувь хүний нууц нь дараах төрөлтэй байна: 1/захидал харилцааны нууц; 2/эрүүл мэндийн нууц; 3/хөрөнгийн нууц; 4/гэр бүлийн нууц; 5/хуулиар тогтоосон бусад нууц.
3.	Ашигт малтмалын тухай хууль <i>/шинэчилсэн найруулга/</i>	57.2.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулах бөгөөд мэдээ, тайланг хүлээлгэн өгөхдөө нууц хадгалах талаар гэрээ байгуулж болно. 57.3.Энэ хуулийн 57.2-т заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, <u>Хувь хүний нууцын тухай хуульд заасан үндэслэл</u> , журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.
4.	Банкны тухай хууль <i>/шинэчилсэн найруулга/</i>	7 дугаар зүйл. банканд хориглох үйл ажиллагаа 7.2. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл, ажилтанд хориглоно: 7.2.1 тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн; 65.3.3.мэдээ, мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, хамгаалалт нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх.

5.	Байгууллагын нууцын тухай хууль	5.3.Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн <u>хувь хүний нууцыг</u> байгууллагын нууцын нэг адил хамгаална.
6.	Гаалийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	5.3.Гаалийн байгууллага, албан тушаалтнаас гаалийн хууль тогтоомжийн дагуу авсан төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг <u>нууцын хууль тогтоомжоор</u> зохицуулна. 69.2.5. <u>мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байх;</u> 274.2.1.өргөсөн тангарагтаа үнэнч, гаалийн хяналт, шалгалтыг хийхдээ сонор сэрэмжтэй байж, төр, байгууллага болон <u>хувь хүний нууцыг чанд хадгалж, хувь хүний нэр хүндийг гутаахгүй байх;</u>
7.	Гүйцэтгэх ажлын тухай хууль	8.7.Гүйцэтгэх ажлын явцад хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль ёсны ашиг сонирхолд нь халдах, гүйцэтгэх ажлын үр дүнг хууль бусаар ашиглах, гүйцэтгэх ажлын мэдээ, баримт сэлтийг хуурамчаар үйлдэх, хуульд зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх ажлын явцад олсон <u>хувь хүний нууцад</u> хамаарах мэдээллийг задруулахыг хориглоно.
8.	Гэр бүлийн тухай хууль	8.4. гэрлэхийг хүсэгчдийн шинжилгээний хариу нь эмнэлгийн байгууллагын нууц байна. 60.1. үрчлэлтийн нууцыг мэдэж байгаа албан тушаалтан, бусад этгээд түүнийг хадгалах үүрэгтэй. 60.2. үрчлэгч болон <u>үрчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үрчлэлтийн нууцыг задруулсан</u> бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
9.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/	7.2.Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, <u>хувийн нууц</u> , нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно. 8.1.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авсан, хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний <u>хувийн мэдээллийг нууцлах</u> , задруулахаас урьдчилан сэргийлэх; 23.6.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан мэдээлэл өгсөн этгээдийн талаарх мэдээллийг нууцлах үүрэгтэй. 42.3.Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, <u>нууцлалыг хангана</u> .
10.	Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль	9.1.1. тодорхой хүний хувийн амьдрал, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй холбоотой баримт мэдээ цуглуулах, хэвлэн нийтлэх; 9.1.3. <u>үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр</u> тэдгээрийн тухай аливаа <u>мэдээллийг</u> иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх;
11.	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль	43 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах 43.1. зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно: 43.1.1. тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд; 43.1.2. даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани; 43.1.3. үйлчлүүлэгч, эсхүл үйлчлүүлэгч байсан этгээд.

		43.2. дараах тохиолдолд энэ хуулийн 43.1 дэх хэсэг хамаарахгүй: 43.2.1 <u>тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;</u> 43.2.2. зохицуулах хороо шаардсан; 43.2.3. шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан; 43.2.4. энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай; 43.2.5. уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн; 43.2.6. тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 43.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх; 43.2.7. энэ хуулийн 35.1-д заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.
12.	Засгийн газрын тухай хууль	25.4.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон <u>захидал харилцааны нууцыг</u> задруулахыг хориглоно.
13.	Иргэний хууль	21.4.Хуулиар тогтоосон <u>хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас</u> гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. 21.7.<u>Нас барсан этгээдийн нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг энэ хуулийн 520 дугаар зүйлд заасан өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан</u> бол энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ. 49.3.Талуудын худалдааны нууцыг агуулсан, тэдний зөвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлно. 21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр <u>өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр</u> нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.
14.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	8 дугаар зүйл. шүүх хуралдааныг нээлттэй явуулах 2.Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төр, байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарах бол</u> хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно. 4.хаалттай хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> шүүгч, хуралдаанд оролцогчид задруулж болохгүй. 38.6.Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ. 46.3.Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай, төр, байгууллага, <u>хувь хүний нууцтай</u> холбоотойгоос бусад нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр холбогдох иргэн, хуулийн этгээд түүний албан тушаалтан гаргаж өгөх үүрэгтэй. 86 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг 86.2.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, <u>хувь хүний</u>

		<u>нууцтай</u> холбоотой асуудлын нууцыг задруулахгүй байх; 110.2.Хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдсон баримтыг шүүх хуралдаанд танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал бичгийг <u>тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр</u> нээлттэй шүүх хуралдаанд уншин сонгож болно. Хэрэв зөвшөөрөл аваагүй бол хувийн захидал, бичгийг уншин сонгох ба шинжлэх явдлыг хаалттай шүүх хуралдаанаар гүйцэтгэнэ.
15.	Монгол улсын ерөнхийлөгчийн тухай хууль	16 дугаар зүйл. ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа 1.ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах баталгаагаар хангагдана: 5.ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон <u>захидал харилцааны нууцыг</u> задруулахыг хориглоно.
16.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	48 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны ёс зүйн шаардлага, хориглох зүйл 48.2.1.ажил, албан тушаалын журмаар олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллага, <u>хувь хүний нууцыг хувийн зорилгоор ашиглах</u> , эсхүл бусдад мэдээлэх, задруулах;
17.	Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	25.1.Комиссын гишүүн гомдол, мэдээлэл шалгах чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 25.1.7.хуульд заасан журмын дагуу төрийн болон албаны, байгууллагын болон хувь хүний нууцтай саадгүй, даруй танилцах. 26.2.Комиссын гишүүн албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн болон албаны, байгууллагын болон <u>хувь хүний нууцыг чандлан</u> хадгална. 41.1.Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно: 41.1.3.албан үүрэгтэй нь холбогдож мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллагын болон <u>хувь хүний нууцыг задруулах</u> ;
18.	Монгол улсын Шүүхийн тухай хууль	8.7.Шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай төр, <u>хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахгүй мэдээллийг</u> хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж байна.
19.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	18.1.3.хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> хамгаалах шаардлагатай бол; 20 дугаар зүйл.Хувь хүний нууцыг хамгаалах 20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.
20.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	25 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нээлттэй байлгах 25.3.Албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь <u>хувь хүний нууцад</u> хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний

	урьдчилан сэргийлэх тухай хууль	нууцын тухай хуулиар зохицуулна.
21.	Нотариатын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	22 дугаар зүйл.Нотариатын мэргэжлийн нууц 22.1.Нотариатч төр, байгууллага, <u>хувь хүний нууцад</u> хамаарах асуудлаар нотариатын үйлдэл хийж байгаа бол тэдгээрийн нууцыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаална.
22.	Өмгөөллийн тухай хууль	14 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн үүрэг 14.1.4.өмгөөллийн нууц, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллагын, <u>хувь хүний нууцыг</u> задруулахгүй байх; 20 дугаар зүйл.Өмгөөлөгчийн хүсэлт 20.3.Өмгөөлөгчийн хүсэлтэд заасан баримт сэлт, мэдээлэл нь хууль тогтоомжийн дагуу төрийн болон албаны, эсхүл байгууллагын, <u>хувь хүний нууцад</u> хамаарахаар бол нууц задруулахгүй байх баталгааг гаргаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу танилцаж болно.
23.	Прокурорын тухай хууль /шинэчилсэн найруулга/	58.3.Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь, эсхүл хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр, бусад прокурорыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, тээвэр, холбооны хэрэгсэл, өөрийнх нь мэдэлд байгаа баримт бичиг, ачаа тээш, бусад эд хөрөнгө, захидал, харилцаа, <u>хувийн нууц</u> , биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. 58.8.Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр бусад байгууллага, албан тушаалтан прокурорын хяналтын ажлыг шалгах, албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцын талаар мэдээлэл өгөхийг</u> прокуророос шаардахыг хориглоно.
24.	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль	7.3.Эрүүлжүүлэх байрны ажилтанд дараах зүйл хийхийг хориглоно: 7.3.4.үйлчлүүлэгч этгээдийг эрүүлжүүлэх байранд байх хугацаанд олж мэдсэн <u>хувь хүний нууцыг задруулах</u> , нэр хүндэд нь халдсан мэдээлэл тараах;
25.	Соёлын тухай хууль	19.4. уран бүтээлчийн үүдэл санаа, ур чадварын нууцыг <u>түүний зөвшөөрөлгүйгээр</u> задруулахыг хориглоно.
26.	Тагнуулын байгууллагын тухай хууль	17¹ дүгээр зүйл.Тагнуулын ажилтны эрх, үүрэг 17 ¹ .1.6.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> хамгаалах;
27.	Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/	34 дүгээр зүйл.Бусад байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах 34.5.1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт

		байгаа <u>хувь хүний нууцад</u> үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр;
28.	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль	17 дугаар зүйл. төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог 1. төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 2/ <u>хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр</u> хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хувийн нууцынх нь талаар хэвлэн нийтлэх; 15.8. хамгаалуулагчийн <u>хувийн нууцыг чанд хадгалах</u> ; 17.2. <u>хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр</u> хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хувийн нууцынх нь талаар хэвлэн нийтлэх;
29.	Улсын бүртгэлийн ерөнхий хууль <i>/Шинэчилсэн найруулга/</i>	18.7.3.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> задруулахгүй байх; 19.4.12.улсын бүртгэлтэй холбоотой төрийн болон албаны нууц, <u>байгууллага, хувь хүний нууцыг</u> задруулахгүй байх;
30.	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	12 дугаар зүйл. Төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо 12.1.Төрийн байгууллага, албан тушаалтан үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар тогтоосон журмыг сахин биелүүлэх төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> чанд хамгаалах, өөрийн хууль ёсны үүрэгт хамаарах мэдээ баримтыг холбогдох дээд байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй. 14 дүгээр зүйл. Иргэний оролцоо 14.1.Монгол Улсын иргэн үндэсний язгуур ашиг сонирхлоо дээдэлж, хуулиар тогтоосон үүргээ биелүүлэх, төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг задруулахгүй</u> байх үүрэгтэй.
31.	Харилцаа холбооны тухай хууль <i>/шинэчилсэн найруулга/</i>	6.1.7.харилцаа холбооны үйлчилгээг найдвартай, шуурхай, чанартай байлгах, <u>захидал харилцааны нууцын хамгаалалтад</u> хяналт тавих; 15.1.2.харилцаа холбоо, <u>захидал харилцааны нууц</u> задруулсан; 25.2.4.харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах;
32.	Авлигын эсрэг хууль	8 дугаар зүйл.Авлигын тухай мэдэгдэх 8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй. 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, <u>хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй</u> . 12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газарт хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь <u>хувь хүний нууцад хамаарах</u> бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна. 12.2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үүрэг хүлээсэн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойших хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон хуульд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг гаргагчийн болон энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийг задруулах, ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

		12.3.Энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд <u>Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.</u> 25.1.2.албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон буюу өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг задруулах;</u> 25.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байх үедээ өөрт нь илэрхий болсон нууцыг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.
33.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль	15.2.Хуульчийн шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох шалгалтад оролцогчийн нэр нууцлагдсан байна. 28.2.Энэ хуулийн 28.1-д заасан хуульчийн мэдэгдэх үүрэг нь энэ хуулийн 33.1-д заасан мэдээлэл болон Хуульчдын холбооны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа олж мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцад хамаарах мэдээллийг задруулахыг шаардахгүй.</u> 33.1.Хуульчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууцад хамаарна. Хуульч үйлчлүүлэгчийнхээ зөвшөөрөлгүйгээр мэдээллийг задруулах эрхгүй.
34.	Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль	10.1.5.хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан, дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон ажилтныхаа <u>нууцыг хамгаалах,</u> түүний талаарх энэ хуулийн 11.3-т заасан мэдээллийг бусдад задруулахгүй байх; 1.3.Байгууллага, албан тушаалтан, иргэн нь хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой <u>хүний талаарх мэдээллийг</u> хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно. 11.4.Энэ хуулийн 11.3-т заасан мэдээлэлд хүний дархлал хомсдолын вирусийн халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, ажлын, сургуулийн болон байнга оршин суугаа газрын хаяг, онцлог тэмдэг, гэрэл зураг, утасны дугаар, шинжилгээний хариу хамаарна.
35.	Хүүхдийн эрхийн тухай хууль	7.3.Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй. 10.1.6.хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, <u>хувийн нууцыг хадгалж,</u> хувийн орон зайг хамгаалах;
36.	Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/	38.2.Хүнийг эрэн сурвалжлах тохиолдолд түүний ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, үндсэн захиргаа, гэрэл зураг, биеийн өндөр, жин, онцлог содон тэмдэг, эрэн сурвалжлах үндэслэл <u>зэрэг Хувь хүний нууцын тухай хуулиар хориглоогүй мэдээллийг</u> олон нийтэд мэдээлж болно. 38.3.Хүний амь нас, эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор террор үйлдэх, хүн худалдаалах, хүнийг алах, авлига, хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн болон зохион байгуулалттай гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүн, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны <u>хувийн эрүүл мэндийн нууцад хамаарах</u> бие эрхтний гажиг, халдварт өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг хуульд заасны дагуу олон нийтэд мэдээлж болно. 68.5.Хуульд зааснаас бусад тохиолдолд цагдаагийн алба хаагч <u>хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг хайх, цуглуулах, хэрэглэх, тараахыг хориглоно.</u>

		29.16.Хүний бие, эд зүйлд үзлэг хийхдээ үүрэн холбооны хэрэгсэл, цахим төхөөрөмж зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах хэрэгсэлд прокурорын зөвшөөрөлгүйгээр үзлэг хийхийг хориглоно. 69.1.4.төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах</u> , удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх
37.	Шуудангийн тухай хууль	5.1.5. <u>үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах</u> , хамгаалах; 24.2. шуудангийн сүлжээгээр дамжиж байгаа бүх төрлийн илгээмжийг алдаж үрэгдүүлэх, гэмтээх, зохих зөвшөөрөлгүй задлах, мэдээллийн нууцыг задруулах болон шуудангийн маркийг хуурамчаар үйлдвэрлэх, хуулбарлахыг хориглоно.
38.	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль	27 дугаар зүйл.Шүүгчид хориглох зүйл 27.1.3.албан үүрэгтэй нь холбогдож, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;
39.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль <i>/Шинэчилсэн найруулга/</i>	7.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, <u>хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг</u> хориглоно. 273.2.4.төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах</u> , удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх; 283.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн талаарх судалгаа, мэдээ, мэдээллийг <u>түүний зөвшөөрөлгүйгээр</u> бусдад задруулахыг хориглоно. 260 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын чиг үүрэг 260.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага энэ хуулийн 260.1.7-д заасан чиг үүргийн хүрээнд алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд төр, байгууллага, <u>хувь хүний нууцын</u> хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тэдгээрт холбогдох хууль тогтоомж зөрчих, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлүүлэх зэргээр байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангана.
40.	Шүүхийн шинжилгээний тухай хууль	14 дүгээр зүйл.Шинжээчийн үүрэг 14.1.4.шинжилгээ хийх явцад илэрхий болсон төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг хадгалах</u> ; 15 дугаар зүйл.Шинжээчийн үйл ажиллагаанд хориглох зүйл 15.1.7.шинжилгээний явцад олж мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг задруулах</u> , түүнийг хувийн сонирхлоор ашиглах;
41.	Эрүүгийн хууль <i>/шинэчилсэн найруулга/</i>	13.10 дугаар зүйл.Хувь хүний нууцад халдах 1.Хуулиар хамгаалагдсан <u>хувь хүний нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан</u> бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах 1.Хуулиар хамгаалагдсан <u>хувь хүний нууцыг олж мэдсэн хүн</u>

	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/	<u>өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан</u> бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. <u>2.Энэ гэмт хэргийг <u>хувь хүний, ажил хэргийн, худалдаа арилжааны нууцыг</u></u> ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн эмнэлгийн мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгч, хуульч, хууль сахиулагч, нотариатч, нийгмийн ажилтан, төрийн албан хаагч, сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч, банкны ажилтан, аудитор үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах 1.Төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна. 5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг: 2.9.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, <u>хувь хүний нууцад</u> хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах; 8.3 дугаар зүйл.Мэдээллээр хангуулах 3.Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, <u>хувь хүний нууцтай</u> холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй. 9.4 дүгээр зүйл.Орчуулагч, хэлмэрч 3.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууц</u>, хэргийн талаарх баримт, мэдээллийг задруулахгүй байх; 23.2 дугаар зүйл.Хүний биед үзлэг хийх 4.Нүцгэлж хийх үзлэгийг хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, <u>хувь хүний нууцыг</u> хамгаалах шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд явуулна. 23.3 дугаар зүйл.Хэргийн газрын үзлэг 3.11.төр, <u>хувь хүний нууцад</u> хамаарах мэдээлэл алдагдах, эд хөрөнгө устгах, үрэгдэхээс хамгаалах. 29.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал 2.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авна. 3.Мөрдөгч төр, байгууллага, <u>хувь хүний нууцтай</u> холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна. 34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах 2.1.төр, байгууллага, <u>хувь хүний нууцтай</u> холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;
--	---	---

44.	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/	40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт 40.4.Тусламж үзүүлэгч тал дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.2.<u>хувь хүний нууцыг задруулах</u>;
45.	Донорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	4 дүгээр зүйл.Донорын үйл ажиллагаанд баримтлах зарчим 4.1.Донорын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 4.1.5.<u>хувь хүний нууцыг хамгаалах</u>; 9.1.Зохицуулах алба нь донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах талаар дараах эрх, үүрэгтэй: 9.1.8.донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой байгууллага, <u>хувь хүний нууцыг хамгаалах</u>.
46.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	24 дүгээр зүйл.Жендерийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаарх гомдлыг хянан шийдвэрлэх 24.4.Бэлгийн дарамтын талаарх гомдлыг хянан шийдвэрлэх явцад илэрсэн хувь хүнтэй холбоотой мэдээллийг хувийн нууц гэж үзэж, <u>Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаална</u>.
47.	Захиргааны ерөнхий хууль i хэсэг ерөнхий үндэслэл	10 дугаар зүйл.Захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг 10.4.Захиргааны байгууллага дараах тохиолдолд туслалцаа үзүүлэхгүй: 10.4.3.тухайн асуудал Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, <u>Хувь хүний нууцын тухай хуулиар туслалцаа</u> үзүүлэх боломжгүй бол. 15.2.Энэ хуулийн 15.1-д заасан мэдээлэл авах эрх төр, байгууллага, <u>хувь хүний нууцын тухай</u> хууль тогтоомжоор хамгаалагдсан мэдээллээр хязгаарлагдана. 28 дугаар зүйл.Сонсох ажиллагааг хийхгүй байх 28.1.Дараах тохиолдолд сонсох ажиллагаа хийхгүй байж болно: 28.1.6.төр, байгууллага, <u>хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор</u> хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол. 30 дугаар зүйл.Нууцыг хадгалах 30.1.Оролцогч төр, байгууллага болон <u>хувь хүний нууцыг задруулахгүй байхыг</u> захиргааны байгууллагаас шаардах эрхтэй.
48.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/	9 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах 9.2.Хэргийн нотлох баримт, үйл явдал төр, байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарах бол</u> хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шүүх хуралдааныг бүрэн, эсхүл түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно. 31 дүгээр зүйл. Нотлох баримт 31.3.Хаалттай шүүх хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг</u> шүүгч, шүүх хуралдаанд оролцогч задруулахыг хориглоно. 75 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг 75.2.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх; 101.2.Хуульд заасан төр, байгууллага, <u>хувь хүний нууцтай холбогдсон баримтыг</u> хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад

		танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал, бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгөөр нээлттэй шүүх хуралдаанд уншин сонсож болно. Хэрэв зөвшөөрөл аваагүй бол хувийн захидал, бичгийг уншин сонсох болон шинжлэх ажиллагааг хаалттай шүүх хуралдаанаар гүйцэтгэнэ.
49.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	4.Өмгөөлөгч дараах эрхтэй: 4.9.зөрчлийн хэрэгтэй танилцаж, төр, байгууллага, <u>хувь хүний нууцад</u> хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах; 4.Орчуулагч, хэлмэрч дараах үүрэгтэй: 4.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууц</u> , зөрчлийн хэргийн талаарх мэдээллийг задруулахгүй байх; 4.4 дүгээр зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах 1.Эрх бүхий албан тушаалтан нь байгууллага, <u>хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл</u> , баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.
50.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	7 дугаар зүйл.Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг 5/өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг хадгалах</u> ;
51.	Нийгмийн халамжийн тухай хууль	27 дугаар зүйл.Амьжиргааг дэмжих зөвлөл 27.7.Зөвлөлийн шийдвэр нь <u>Хувь хүний нууцын тухай хуульд зааснаас</u> бусад тохиолдолд нийтэд нээлттэй, ил тод байна.
52.	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль	34 дүгээр зүйл.Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах 34.1.Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон <u>хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг</u> олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй.
53.	Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	15.2.Энэ хуулийн 6.4-т зааснаас бусад тохиолдолд төрийн аудитын байгууллага аудит хийхдээ зөвхөн Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, түүнчлэн шалгадагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарах мэдээлэл</u> , баримт бичгийн зөвхөн тухайн харилцаатай холбогдох хэсэгтэй хуульд заасан журмын дагуу танилцах, хэвлэх, олшруулж авах эрхтэй. 15.3.Төрийн болон албаны, байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарах мэдээлэл</u> , баримт бичигтэй танилцсан төрийн аудитын байгууллагын албан хаагч уг мэдээлэл, баримт бичгийг холбогдох хуульд заасны дагуу нууцлах үүрэг хүлээнэ. 37.2.Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны, байгууллагын, <u>хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг</u> Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар

		олон нийтэд мэдээлнэ. 37.3.Төрийн аудитын байгууллага хүсэлт гаргасан этгээдэд төрийн болон байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарах мэдээлэл</u> агуулснаас бусад аудитын тайланг хуульд заасан журмын дагуу өгч болно. 38.8.Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвшөөрөлгүйгээр бусад байгууллага, албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдож өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллагын, <u>хувь хүний нууцын талаар</u> мэдээлэл өгөхийг төрийн аудитын байгууллагын албан хаагчаас шаардахыг хориглоно.
54.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	4. Шинжээч нь дараах эрх, үүрэгтэй: 4/ үйл ажиллагааныхаа явцад хүлээн авсан бичиг баримтаас мэдсэн төр, байгууллага, <u>хувь хүний нууцыг задруулахгүй байх</u>;
55.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль	19 дүгээр зүйл.Хэргийн материалтай танилцах 19.1.Цагаатгагдсан хэлмэгдэгч, түүний төрөл садан нь хэрэгсэхгүй болгосон хэргийн баримт сэлттэй танилцаж, төр, байгууллага, <u>хувь хүний нууцад хамаарахгүй</u> баримт сэлтийн хуулбарыг авч болно. Ийнхүү авсан баримт сэлтийг тухайн хэрэгт холбогдолтой хүмүүсийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд харшаар ашиглахыг хориглоно.
56.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль <i>/шинэчилсэн найруулга/</i>	30.1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 30.1.12.хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар байгууллага, <u>хувь хүний нууцад</u> хамаарахаас бусад шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах
57.	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль	18 дугаар зүйл. Тооллогын мэдээллийн нууцлал, хадгалалт, хамгаалалт 18.1.Тооллогын мэдээлэл хуульд заасны дагуу <u>хувь хүний нууцад хамаарах</u> бөгөөд мэдээллийн нууцлалыг дор дурдсан хугацаанд задруулахыг хориглоно:
58.	Цахим гарын үсгийн тухай хууль	29.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ: 29.2.11.тоон гарын үсэг эзэмшигчийн <u>хувь хүний нууцыг задруулахгүй</u>, гэрчилгээнд зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахгүй байх;
59	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын	6.1.Цэргийн алба хаагч дараах нийтлэг үүрэгтэй: 6.1.9.төрийн болон албаны, байгууллагын, <u>хувь хүний нууцыг</u> алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй

	тухай хууль	байх;
--	--------------------	-------

ХАВСРАЛТ 2

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ЗОХИЦУУЛАЛТ АГУУЛСАН ХУУЛИЙН ЗААЛТЫН ТҮҮВЭР

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хуулиудад мэдээллийн аюулгүй байдлын талаар зохицуулалт тусгагдсан байна.

№	Хуулийн нэр	Хуулийн заалт
1.	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль	5.1.Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглахад дараах үндсэн зарчмыг баримтална: 5.1.6.сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн санд байгаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах; 10 дугаар зүйл.Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах талаарх сонгуулийн хороодын бүрэн эрх 10.1.2.мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих; 10.3.Сонгуулийн хэсгийн хороо нь сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.3.2.автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл дэх мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах; 12.3.Мэдээллийн технологийн төв нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан дүрмийг мөрдлөг болгон ажиллаж дараах үүргийг гүйцэтгэнэ: 12.3.5. сонгуулийн автоматжуулсан систем дэх мэдээллийн аюулгүй байдлыг хариуцан хангах;
2.	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	3 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт 3.4.Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 3.4.6. мэдээллийн аюулгүй байдал 18.1. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл харилцан солилцох, Зөвлөлөөс гарах шийдвэрийн төсөл боловсруулахад туслах болон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдөх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсгийг дор дурдсанаар Зөвлөлийн дэргэд байгуулна: 18.1.2. Мэдээллийн аюулгүй байдлын;
3.	Ард нийтийн санал асуулгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/	19 дүгээр зүйл. Санал тоолох 19.11.Саналын хуудасны мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор энэ хуулийн 19.10-т заасны дагуу битүүмжилсэн саналын хуудасны битүүмжлэлийг задлахгүйгээр холбогдох журамд заасны дагуу аймаг, нийслэлийн архивт хадгална
4.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	19.1.Төрийн архивын талаар тухайн архивыг харьяалж байгаа төрийн байгууллагын удирдлага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ: 19.1.2.архивт шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийг шийдвэрлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах; 24.1.Байгууллагын архивын талаар тухайн байгууллагын удирдлага дараах үүрэг хүлээнэ: 24.1.3.архивт шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл,

		программ хангамжийг шийдвэрлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
5.	Зээлийн мэдээллийн тухай хууль	16.2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах үүрэгтэй: 16.2.4.зээлийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг тогтмол сайжруулах замаар эрх олгогдоогүй этгээдэд мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
6.	Эрүүгийн хууль <i>/Шинэчилсэн найруулга/</i>	26.1 дүгээр зүйл.Цахим мэдээлэлд хууль бусаар халдах 1.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерийн өгөгдөл, системд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн өгөгдлийг нуусан, хандалтад хязгаарлалт тогтоосон, компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагааг хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан; энэ гэмт хэргийг хүн амын амьдралыг хангах объектод халдаж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг: 4.1.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн; 4.2.төрийн нууцад хамаарах компьютерийн өгөгдөл, онц чухал мэдээллийн сүлжээ, компьютерийн сүлжээнд халдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 26.2 дугаар зүйл.Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах 1.Цахим төхөөрөмж, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ, техник хэрэгслийг бэлтгэсэн, борлуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 26.3 дугаар зүйл.Хор хөнөөлт программ хангамж бүтээх,

		ашиглах, тараах 1.Цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, гэмтээх, өөрчлөх, хуулбарлах, мэдээлэл олж авах, программ хангамж, мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмж, сүлжээг ашиглах боломжгүй болгох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зориулалттай хор хөнөөлт программ хангамжийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
7.	Тагнуулын байгууллагын тухай хууль	10 дугаар зүйл. Тагнуулын ерөнхий газар, түүний чиг үүрэг 10.4.Тагнуулын ерөнхий газар нь гадаад тагнуул, сөрөх тагнуул, эдийн засгийн тагнуул, цэрэг-стратегийн тагнуул, хилийн тагнуул, тэдгээрт дэмжлэг үзүүлэх, мэдээллийн дүн шинжилгээ хийх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мөрдөн байцаах, дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах болон захиргаа, удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн бүтэцтэй байна.
8.	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль	10.1.Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд дараах шаардлага тавина: 10.1.7.үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
9.	Төрийн болон албаны нууцын тухай хууль	13.1.Төрийн нууцад дараахь мэдээллийг хамааруулна: 13.1.5.<u>мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд:</u> 13.1.5.а.төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл; 13.1.5.б.төрийн мэдээллийн сүлжээний удирдлагын төвийн тусгай зориулалтын техник, программ хангамж; 13.1.5.в.төрийн шифр харилцааны бодлого, төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны болон шифрийн криптографын боловсруулалт, сан, нөөц, шифрийн арга ажиллагаа, аргачлал, тэдгээрийг ашиглах заавар, код, түлхүүр, түүнтэй холбоотой мэдээлэл; 13.1.5.г.төрийн шифр мэдээ, шифрийн харилцааны дүрэм, заавар, шифрийн материалын бүртгэл; 13.1.5.д.төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл; 13.1.5.е.төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл; 13.1.5.ё.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл; 13.1.5.ж.хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл; 13.1.5.з.улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн

		тухай мэдээлэл; 13.1.5.и.цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг; 13.1.5.й.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл үйл ажиллагаа; 13.1.5.к.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг 13.1.5.л.хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн тухай мэдээлэл; 13.1.5.м.улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам.
10.	Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/	11 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан 11.5.Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр дараах эрх, үүрэгтэй байна: 11.5.4.эрсдлийн үнэлгээг жил бүр хийж, мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх болон авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах;
11.	Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/	61 дүгээр зүйл. Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах 61.2.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 61.1-д заасан мэдээллийн санг энэ хуульд заасан зорилгоор ашиглах бөгөөд уг сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
12.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	34 дүгээр зүйл. Нотариатч мэдээлэл нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага 34.1.Нотариатч мэдээлэл нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байна: 34.1.1.үйлчлүүлэгчийн хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

ХАВСРАЛТ 3

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Нийцэж байгаа
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Асуудал тус бүрээр бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх нөлөөг тооцсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц	Тийм		Иргэн, хувь хүний эрх ашгийг хамгаална.

	дэвшил гарах эсэх			
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	Хязгаарлалт байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Хязгаарлалт байхгүй
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр	Тийм		

	хязгаарлахгүй)			
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		Тухайлбал, хил дамнаулан хувь хүний мэдээллийг дамжуулахыг хориглоно. Тухайн иргэний зөвшөөрөлтэй тохиолдолд боломжтой.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	худалдан авахад хүргэх эсэх			
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм		Хүний эрхийн үндэсний комисст нэмэлт зардал үүснэ.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах		Үгүй	Ямар сөрөг байхгүй. нэгэн нөлөө

	боломж олгох эсэх			
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдана.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Хувь хүний мэдээллийг хамгаалах, энэ чиглэлээр санал гомдол хүлээн авах, хяналт тавих эрх бүхий албан тушаал гарах боломжтой.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		Хүний эрхийн үндэсний комисст шинэ чиг үүрэг нэмэх
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Хүний эрхийн үндэсний комисст шинэ чиг үүрэг нэмэх
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах	Тийм		Хувь хүний мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн орчин

	зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			бий болсноор гаднын хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар сөрөг нэгэн нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Хувь хүний мэдээлэл хамгаалах чиглэлээр нэгдэн орсон конвенц, олон улсын гэрээ одоогоор байхгүй.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хүний эрхийн үндэсний комисст шинэ чиг үүрэг нэмэх
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Хувь хүний мэдээллийг цуглуулах талаар үйлчилгээний чанарт өөрчлөлт гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		Хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах талаар ажилчдад сургалт явуулах шаардлагатай.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Хувь хүний мэдээллийг хувь хүний зөвшөөрөлгүйгээр ашиглах, ил болгохтой холбоотой гэмт

				хэрэг буурна гэж үзэж байна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

байгалийн баялаг	зохистой ашиглах эсэх			
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Ашигласан эх сурвалж

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хувь хүний нууцын тухай хууль, 1995.
3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001.
4. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
5. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1946.
6. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын акт, 1966.
7. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 45/95 тоот тогтоол, 1990
8. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 2005.
9. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Их хурлын 41 дүгээр тоот тогтоол, 2003.
10. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 2010.
11. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 45 дугаар тогтоол, 2016.
12. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газар 204 дүгээр тогтоол, 2016.
13. Монгол улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Их хурлын 11 дүгээр тогтоол, 2017.
14. Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын Их хурлын 54 дүгээр тогтоол, 2018.
15. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр Тогтоол, 2020.
16. Алсын хараа-2050, Монгол Улсын Их хурлын 52 дугаар тогтоол, 2020.
17. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол, 2020.
18. Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025, Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоол, 2017.
19. Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/477 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах /ерөнхий/ журам.

Хоёр. Эрдэм шинжилгээний өгүүлэл, ном

1. Монгол Улсын Иргэний хуульд холбогдох баримт бичиг (2001-2002), УБ 2018.
2. Монголын эрх зүйн эх толь бичиг(дөрөв дэх хэвлэлт), УБ 2015.
3. Ц.Сарантуяа, Үндсэн хууль төр ба үндсэн эрх, эрх чөлөө эрдэм шинжилгээний өгүүлэл, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа, шинжилгээний тойм. УБ 2019.
4. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, 5 боть. Шинжлэх ухааны академи, УБ., 2007 он.
- 5, Ж.Амарсанаа, Хууль зүйн нэр томъёоны булан, Хууль дээдлэх ёс сэтгүүл (№3), 2019 он,

Гурав. Судалгаа

1. Монгол улсын Шүүхийн тайлан, 2019 он.
2. Цагдаагийн ерөнхий газраас тодорхой төрлийн гомдол мэдээллийн судалгаа, 2020.
3. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн зарим гэмт хэргийн тоон мэдээлэл /2020-12-16/.
4. Монгол Улс Хэвлэл мэдээллийн эрх зүй. Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх (Сургалтын гарын авлага), Глоб интернэшнл төв болон DW akademie, 2017.
5. Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /харьцуулсан судалгаа/, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2018.

Дөрөв. Цахим эх сурвалж

1. www.legalinfo.mn
2. https://judcouncil.mn/site/site/news_full/10084
3. <https://unctad.org/page/data-protection-and-privacy-legislation-worldwide>
4. <https://www.delltechnologies.com/en-us/data-protection/gdpr/index.htm>
5. https://www.privacy.go.kr/eng/laws_view.do?nttId=8186&imgNo=3
6. <https://sso.agc.gov.sg/Act/PDPA2012>
7. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2781&vm=2&re=02>
8. <https://www.privacy-regulation.eu/en/index.htm>
9. <https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/contents/enacted>
10. <https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2018/en20181050.pdf>
11. <https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19920153/index.html>
12. <https://www.riigiteataja.ee/en/eli/523012019001/consolide>-Эстони
13. <https://www.justice.gov/opcl/overview-privacy-act-1974-2020-edition>
14. <https://laws-lois.justice.gc.ca/ENG/ACTS/P-8.6/index.html>
15. <https://www.qp.alberta.ca/documents/Acts/P06P5.pdf>
16. <http://legisquebec.gouv.qc.ca/en/showdoc/cs/P-39.1>
17. https://www.bclaws.ca/civix/document/id/complete/statreg/03063_01
18. <https://gdpr-info.eu/art-4-gdpr/>
19. <https://cis-legislation.com/document.fwx?rgn=116757>
20. <https://www.forbes.com/top-digital-companies/list/?fbclid=IwAR3FByv-RQXOxq94KXNxJTq9ftW89XIaBIaCMuJLzDgWvmDBrcWaRysyBRA#tab:rank>
https://www.forbes.com/just-companies/?fbclid=IwAR0xv1IN9km_k4mQ6Dsl_FhKctboBld6SBR9Y2uFDMDDeNQ9UYSuHy2bjbMQ#21be7df62bf0